

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
04 дүгээр сарын 22-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-51

1.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ, үргэлжлэв/	9-10
2.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/	10-46
3.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	46-51

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
04 дүгээр сарын 22-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 22 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Сэддорж, Х.Ганхуяг, Г.Лувсанжамц;

Чөлөөтэй: Б.Мөнхсоёл;

Тасалсан: Х.Баттулга, П.Батчимэг, Ш.Бямбасүрэн, М.Мандхай.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, С.Цэнгүүн нар үг хэлэв.

Нэг.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссан тухай мэдэгдэж, үг хэлэв./10:34/

Л.Соронзонболд: Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан: 11
Бүгд: 15
26.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Худалдааны бодлогын хэлтсийн зөвлөх Э.Нямбаяр, ахлах мэргэжилтэн Б.Баттуяа, Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал Г.Өлзийсайхан, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Л.Төр-Од, мөн танхимын Гадаад худалдаа, экспортыг дэмжих төвийн ахлах Д.Адъяасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, О.Номинчимэг, Б.Найдалаа, О.Цогтгэрэл, Ж.Алдаржавхлан, Б.Жаргалан, П.Сайнзориг, Д.Энхтүвшин, Ө.Шижир, Р.Батболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал Г.Өлзийсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Л.Төр-Од нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, О.Цогтгэрэл, Б.Жаргалан, П.Сайнзориг, Ч.Лодойсамбуу, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Л.Соронзонболд: Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, П.Сайнзориг нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 70.6 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, мөн банкны Банкны санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Зээлийн мэдээллийн албаны дарга ахлах хянан шалгагч Л.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас тогтоосон нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, О.Батнайрамдал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг Монголбанк батална. Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооход ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 16
Бүгд: 17
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 11.8 хувийн саналаар дэмжээгүйд тооцов.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Л.Соронзонболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйл “зургаа хүртэлх” гэснийг “гурван” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 17
Бүгд: 17
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйл “зургаа хүртэлх” гэснийг “таван” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Соронзонболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “зургаа хүртэлх” гэснийг “гурван” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 17
Бүгд: 17
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/-д тус тус даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 64.7 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 48 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 22 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Соронзонболд: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сэддорж орон нутагт томилолттой, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Батболд ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Батшугар ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Ундраа ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Найдалаа ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн хурал давхацсан байна, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг гадаад томилолттой, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц гадаад томилолттой, Улсын Их Хурлын гишүүн Мандхай чөлөөтэй, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл чөлөөтэй байна. Улсын Их Хурлын Байнгын хорооны гишүүдийн ирц 60 хувьтай байгаа тул, байгааг танилцуулъя.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын ЗГ болон ОХУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төсөл, ЗГ 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх эсэх үргэлжилнэ. Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ. 2 дугаар асуудал Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл, ЗГ 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ. 3 дугаар асуудал Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Ганбаатар гишүүн байна. Би өөрөө бас нэг санал байгаа шүү дээ. Цэнгүүн гишүүн. Ганбаатар гишүүн, Цэнгүүн гишүүнээр тасаллаа.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ их чухал асуудлууд хэлэлцэж байгаа л даа. Тэгээд энэ Байнгын хорооны дарга заавал хурал өөрөө даргалах ёстой. Даргын

зөвлөлийн хурал дээр юу гэж яригдсан юм, өмнөх хурлууд дээр юу гэж яригдсан юм. Тэгээд Байнгын хороон дарга энэ чинь 2 дахиа ч болж байгаа. Тэгээд өөрөө ямар ч ажилтай байж болно л доо. Тэгээд ийм чухал ажлууд асуудлуудаа өөрөө байж даргалах ёстой л доо. Тэгээд сураг сонсох нь тойрог дээрээ томилолттой байгаа юм байна гэж ойлголоо. Ийм, би ч энэ Байнгын хороог ч их олон жил даргалсан л даа. Тэгээд энэ их том чухал асуудлуудыг Байнгын хорооны дарга өөрөө энэ чинь өмнө нь хэлэлцүүлж байсан, энэ хуралд бэлтгэж хууль зөрчсөн асуудлыг оруулахгүй байх эрхтэй шүү дээ Байнгын хорооны дарга. Хууль зөрчсөн асуудлыг Байнгын хороо хэлэлцэхгүй байх бүрэн боломжтой. Тэгэхлээр Байнгын хорооны дарга байх үед нь хэлэлцэх нь уг нь зөв дөө. Тэгээд л энэ хурал явж байгаа процессыг харахлаар ингээд л 30, 40 минут хоцордог, ийм байдаггүй л байсан юм даа 76 байхдаа. Тэгээд аягүй бол бараг энэ чинь бүтэн цаг хоцрох нь байна шүү дээ аягүй бол. Тэгэхлээр ийм, ийм зүйл дээр анхаарах хэрэгтэй байна. Хэн Мягмарцэрэн зөвлөх юу гэж үзэж байгаа юм бэ? Энэ 2 асуудал чинь тэгээд Байнгын хорооны дарга Даргын зөвлөлөөс ер нь ямар чиглэл авсан юм бэ, яасан юм бэ? Өмнөх хурлуудын ... ямар байгаа юм бэ? Их Хурлын гишүүдийн дунд зүгээр ингээд хэрүүл хийгээд орхичхож байгаа юм уу, яаж шийдвэрлэх гэж байгаа юм гэдэг нь их, энэ чинь байр суурь чухал шүү дээ энэ чинь.

Намын бүлгүүд шийдвэр гаргасан юм байна. Даргын зөвлөлийн хурал чинь 16 оноос хойш л энэ чинь хуралддаг байсан шүү дээ. Зарим нь Үндсэн хуулийн биш, Үндсэн хуулийн бус л гээд шүүмжлээд байдаг юм. Миний хувьд энэ чинь асуудлыг ярилцаад нэг иймэрхүү чиглэлтэй хэлэлцэх, хэлэлцэхгүй нь зөв, хойшлуулъя эсхүл хэлэлцье гээд нэг чиг гардаг даа тэр хурал дээрээс. Тийм тэгээд тэр хүн байхгүй учраас наадах чинь ер нь энэ 2 том асуудал чинь ер нь тэгээд л хооронд нь хэрэлдүүлээд л орхих гэж байгаа юм уу, хаашаа юм. Миний хувьд дарга өөрөө байх нь зөв дөө. Хэрвээ энэ хүн ийм завгүй юм бол Байнгын хорооны дарга хийхгүй энгийн гишүүн хийх хэрэгтэй шүү дээ. Байнгын хороонд ялангуяа Эдийн засгийн байнгын хороон дарга мөнхийн хуралдаанд сууж байх ёстой, ямар ч асуудал дээр хариулахад бэлэн байх ёстой шүү дээ. Эдийн засгийн холбоотой асуудал гэж байхгүй холбоогүй асуудал гэж. Тэгээд л өглөө чуулган эхэлнэ орой тартал нь суугаад явдаг л байсан юм. Өвдсөн, зовсон ч гэсэн тэгээд л бүтэн суугаад, бүтэн хариулаад л явдаг байсан юм. Тийм биш л болж байгаа харагдаж байна л даа. Энэ санаа зовоож байна шүү.

Л.Соронзонболд: Эдийн засгийн байнгын хорооны дарга хөдөө орон нутагт томилолттой байгаа. Тэгээд Ганбаатар гишүүн үг хэллээ. Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өглөөний мэнд хүргэе. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор асуулт байна. 4 сарын 16-нд бид өмнөх 3 дахь өдөр хуралдсан. Тэгээд тэр үед хуралдаж байхдаа хэлэлцэх асуудлын дарааллаас Батчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явагдаад Евразийн хэлэлцээрийн тухай асуудлыг судалж үзэх шаардлагатай байна гээд тухайн үед хурлаас хэлэлцэх асуудлын дарааллаас бид хасуулсан байгаа. Тэгэхээр өнөөдөр бид энэ асуудлыг эргүүлж авч нөгөө завсарлага аваад буцаад энэ хурал маань үргэлжлээд явж байгаа. Тэгэхээр өмнөх дэгийнхээ дагуу бид нарын гаргасан зарчмынхаа дагуу хэлэлцэх асуудлын тоонд орохгүй юм биш үү?

Л.Соронзонболд: Өмнөх хурал дээр бид Евразийн асуудлыг хойшлуулсан, завсарлага аваагүй асуудал байгаа шүү. Хойшлуулсан, зөвхөн хойшлуулсан шүү. Тийм учраас өнөөдөр орж ирж байгаа. Тэгээд энэ дээр бол Их Хурлын даргын

дэргэдэх зөвлөлөөр намын бүлгүүд ярилцаад тэгээд энэ хурлын товд орсон байгаа учраас өнөөдөр хэлэлцэж байгаа. Тийм учраас өмнөх хурлаар хойшлуулсан л байх нь. Үгүй ээ тэр чинь болохоор өмнөх долоо хоногийн Эдийн засгийн байнгын хорооны хурлаар бид хэлэлцэх асуудлаараа хойшлуулсан. Энэ долоо хоногийн Эдийн засгийн байнгын хороонд хэлэлцэх асуудал Улсын Их Хурлын даргын зөвлөлөөс намын бүлгүүд ярилцаад оруулсан байгаа гэж. Хэлэлцэх асуудал дээр өөр зарчмын, горимын өөр санал байхгүй тул хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ, үргэлжлэв/

Хэлэлцэх асуудал 1. Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын ЗГ болон ОХУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлэг дээр АН-ын бүлгээс 3 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байгаа. Хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн, АН-ын бүлгийн дарга Цогтгэрэлээс энэ дээр санал байна уу? Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе.

О.Цогтгэрэл: Өнгөрсөн хурлаар агаарын хөлгийн түлш дээр нэг улсын төрийн өмчит компанид давуу эрх олгох асуудлаар АН-ын бүлгээс завсарлага авсан. Өчигдөр бүлгийн хурлаар энэ мэдээллийг дахин сонсоод, бүлгээс албан ёсны шийдвэр гарсан. АН-ын бүлэг олонхоороо энэ асуудлыг энэ гэрээний хэлэлцээрийн төслийг энэ байгаа чигээр нь дэмжих боломжгүй гэдэг ийм зарчмын шийдвэр гаргасан.

Ер нь яагаад ийм шийдвэр гаргая гэдэг дээр тайлбар хэлье. Ер нь эдийн засгийн аюулгүй байдал гэдэг чинь хангалт нийлүүлэлтийн сүлжээг олон болгохыг, сонголттой болгохыг хэлнэ гэж ойлгож байгаа. Тэгэхээр бид 1 биш, 2, 3 сонголт одоогийн байдлаар бид нарт байж болох энэ рүү зорих боломж байсан нь урд хөршөөс авч болох, дотоодын үйлдвэрээсээ яваандаа хангаж болох энэ бүх боломжуудаа 1 дүгээрт нь хаачихжээ. 2 дугаарт ер нь ингээд энэ өрсөлдөөнийг хаасан. Ер нь тэгээд зарчмын хувьд энэ өөрөө Монгол Улсад дотоодод жижиглэнгийн худалдаа эрхлэх эрхийг үндсэндээ энэ 2 улсын ЗГ хоорондын хэлэлцээрээр баталгаажуулж байгаа нь хэр зөв зүйтэй юм бэ? Энэ чинь бөөний худалдаагаа эрхлээд Монголын аж ахуйн нэгж, Монголын дотооддоо жижиглэнгийн худалдааны асуудлаа яригдах ёстой. Энэ зарчмын хувьд жижиглэнгийн худалдааны асуудал болж хувирч байна.

Дахиад үндсэн зарчим аюулгүй байдлын зарчим талаасаа ч гэсэн 2 улсын төр аж ахуйн нэгжийн гэрээнд оролцохоос илүүтэйгээр бизнесийн ААН-үүд энэ гэрээ хэлэлцээрээ хийгээд, үндсэндээ жийргэвч болоод эдийн засгийн утгаараа ч, улс төрийн утгаараа ч жийргэвч болоод 2 төрийн асуудал энэ дээр тулахгүйгээр явах нь өөрөө үндэсний аюулгүй байдлын талаасаа ч ач холбогдолтой юм гэдэг зарчмын байр сууриуд гарсан.

Мөн 20 жилийн гэрээтэй холбоотой технологи жилээр биш, сараар өөрчлөгдөж байна. 20 жилийн хугацаанд технологи яаж өөрчлөгдөж болохыг хэн ч таашгүй. Монголтой холбоотой жишээ нь тэр нүүрснээс шингэн түлш гарах

асуудлууд, занарыг ашиглах асуудал, магадгүй устөрөгчийн гээд энэ 20 жилийн хугацаанд хатуу гэрээгээр ингэж хаах чинь өөрөө дахиад энэ техник технологийн хөгжил дэвшлийг бид угтсан энэ эрин зуунд энэ богино хугацаанд өөрчлөлт гарч байгаа үед энэ бүхэн зарчмын хувьд буруу байна гэх зэрэг олон, олон зүйлүүдээр ингэж завсарлага авсан. Ийм ч шалтгаанаар АН-ын бүлэг дэмжээгүй гэдгийг хэлье.

Тэгээд өнөөдөр бид Дэгийн хуулийн дагуу АН-ын бүлэг завсарлагаа үргэлжлүүлж авч болох ёстой. Бид ярилцаад завсарлага үргэлжлүүлж авах нь зохисгүй юм байна. Энэ дээр Эдийн засгийн байнгын хороо шууд саналаа хураагаад шийдэх хэрэгтэй. Тэр тусмаа АН-ын бүлгээс бүлгийн шийдвэр гарсан учраас бүлгээс оролцож байгаа манай 8 гишүүн энд байх ёстой. Энэ 8 гишүүн нь энэ саналыг дэмжихгүй санал өгөх үүрэгтэй. Бусад гишүүдийг энэ асуудлыг дэмжихгүйгээр санал өгөөч гэж уриалж хүсэж байгаа. Энэ өөрөө Дэгийн хууль дээр зохицуулалт нь Эдийн засгийн байнгын хорооны санал Аюулгүй байдлын байнгын хороон дээр очоод, Аюулгүй байдлын байнгын хороо дэмжвэл энэ нэгдсэн чуулганд орохгүйгээр ЗГ-ын хоорондын хэлэлцээр болчих ийм дэгтэй Улсын Их Хурлын тухай хуульд. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо дэмжихгүй санал гаргачихвал мэргэжлийн Байнгын хороо татгалзсан, Аюулгүй байдлын байнгын хороо дэмжсэн ч гэсэн энэ нэгдсэн чуулган руу явах ийм Улсын Их Хурлын тухай хуулийн 75.12 гэдэг ийм заалттай юм байна лээ. Тэгэхээр хэдүүлээ энийг дэмжихгүй санал гаргаад, Аюулгүй байдлын байнгын хороон дээрээ шийдээд, нэгдсэн чуулганаараа энэ асуудлыг шаардлагатай бол тэр 126 гишүүнээрээ асуудлаа өргөн хэлэлцүүлэг хийе гэж шийдэх энэ хууль эрх зүйн боломжийг гаргах нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм. Тийм болохоор Эдийн засгийн байнгын хорооны гишүүд энэ асуудлыг дэмжихгүйгээр санал өгөөч гэж та бүгдээс хүсэж байна. АН-ын бүлэг завсарлагаа дуусгаж байна.

Л.Соронзонболд: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Одоо санал хураалт явуулъя. Санал хураалт. Байхгүй. Түрүүчийн юун дээр ярьчихсан, дуусчихсан. Санал хураалт, зогсооё, байж байгаарай. Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын ЗГ болон ОХУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 26,7 хувийн буюу 4 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй. Санал хураалт явуулж дууслаа. Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын ЗГ болон ОХУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин танилцуулна. Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

10.36 цаг

Хоёр.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцэх асуудал 2. Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя. Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннэмын Гантөмөр танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Эрхэм Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Евразийн чөлөөт худалдааны хэлэлцээрийг Байнгын хороогоороо хэлэлцүүлж байгаад баярлаж байна. Манай улс 24 онд 162 оронтой худалдаа хийсэн байдаг. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 27,4 тэрбум ам.долларт хүрсэн. Энийгээ бид түүхэн дээд амжилт гэж үзнэ. Үүнээс экспорт 15,8 тэрбум ам.долларт хүрсэн, импорт 11,6 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 4,2 тэрбум ам.долларын ашигтай гарсан.

Монгол Улсын нийт экспортын орлогын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаараа бүрдүүлж эдийн засгийн төрөлжилт алга байна. Энэ нь манай улсын эдийн засгийн хувьд хамгийн эмзэг цэг болж байгаа. Төрөлжилт үгүй гэдэг нь. Эдийн засгийн төрөлжилтийг бий болгох, уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, төрөлжилтийг нэмэгдүүлж, экспортын зах зээлийг тэлж худалдааг хөнгөвчлөх чиглэлээр бодитой ажлуудыг хийх хэрэгцээ шаардлага маш өндөр байгаа. Энийг их олон жил ярьсан. Солонгоруулна, эдийн засгийг солонгоруулна, дотоодын үйлдвэртэй болно, өөрийн гэсэн зах зээлтэй болно гэдгийг эдийн засагчид, эдийн засгийн тухай боддог хүмүүс, Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын ЗГ их олон жил ярьж хөөрч зүтгэсэн. Энэний тод жишээ 2050 урт хугацааны хөгжлийн бодлого дотор яг үг үсгээрээ бүс нутгийн интеграцид, эдийн засгийн интеграцид нэгдэх гэдэг ийм заалт байдаг. Хөрш орнуудтайгаа чөлөөт худалдааны хэлэлцээр хийх гэдэг зорилт байдаг. Ялангуяа Евразийн эдийн засгийн холбоотой 2030 он хүртэл чөлөөт худалдааны хэлэлцээр хийнэ гэсэн ийм баримт бичгийг бид батлаад, тэр баримт бичгээ бид дунд хугацааны хөтөлбөр болгоод явж байгаа. Дунд хугацааны хөтөлбөр дотор өнгөрсөн 5 жилийн төлөвлөгөөнд яг энэ үг үсгээрээ орсон. 2024-өөс 2028 оны ЗГ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл дотор яг энэ үг үсгээрээ чөлөөт худалдааны хэлэлцээрийг хийнэ гээд ингээд орчихсон байдаг.

Нийт экспортын 91,2 хувь, түүнээс уул уурхайн бүтээгдэхүүний 94,7 хувийг МАА-н гаралтай бүтээгдэхүүний 82,7 хувийг зөвхөн БНХАУ-д экспортолж байна. Гадаад худалдааны хамаарал хэтэрхий нэг туйлтай байгаа. Ер нь ковидын үед хил хаахад юу болсон бэ гэдгийг энд сууж байгаа бүх хүмүүс, ялангуяа Энхтүвшин гишүүн тухайн үед Аж үйлдвэрийн танхимын дарга байсан байх. Бизнес эрхлэгчид, худалдаачид, хэрэглэгчид гээд бүх түвшиндээ нэг туйлт эдийн засаг ямар байдаг вэ гэдгийг олж харсан. Аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй түвшинд байгаа гэдгийг энэ тоо илтгэж байгаа. Тийм учраас аюулгүйн үзэл баримтлал дотор тэнцвэрийг бий болгох гэдэг заалтыг 2-оос 3 удаа дурдсан байдаг. Эдийн засгийн тэнцвэрийг бий болгоно, худалдааны тэнцвэрийг бий болгож байж Монгол Улс аюулгүй амьдрах нь гэдэг ийм зүйл байгаа. Өөрөөр хэлбэл нэг улс болон цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа эдийн засгийн бүтцийг өөрчилж, олон худалдан авагчид өргөн хүрээний бараа нийлүүлэх тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага бий болоод их удаж байгаа. Тэгээд энэ дээрээ бид шийдвэр гаргаж чаддаггүй. Ийм боломжийг өнөөдөр хүртэл манай хөрш улсууд бид нарт өгөөгүй байгаа. Өгөөгүй байгаа.

ЗГ маш олон удаа асуудлаа тавьдаг манай хөрш улсууд өнөөдөр хүртэл энэ асуудал дээр шийдвэр гаргаагүй. Ингээд өнгөрсөн оны 9 сараас эхлээд энэ асуудлыг ярилцах ийм шийдвэр гарсан. Ингээд 2 удаагийн зөвлөлдөх уулзалт, 3 шатны хэлэлцээг зохион байгуулсан байна. Мөн тус хэлэлцээрийг байгуулах асуудал болон хэлэлцээрийн явцыг нийт 6 удаа ЗГ-ын хуралдаанд танилцуулсан байдаг. Гадаад худалдаа эрхлэгч, бизнес эрхлэгчдийн дунд 4 удаагийн нээлттэй

хэлэлцүүлгийг зохион байгуулсан байдаг. 2023 оны 9 сард хэлэлцээр эхлүүлэхдээ өргөн хүрээний худалдааны чөлөөт худалдааны хэлэлцээр биш тодорхой short гэх юм уу богино лист дээр хэлэлцээр хийе гэдэг ийм саналыг манай Аж үйлдвэрийн танхим бусад газраас гаргасан байдаг. Ингээд ямар бараан дээр хэлэлцээр хийх вэ гэдэг саналыг Эдийн засаг, хөгжлийн яам жишээлбэл бие дааж гаргадаггүй. Энийг Аж үйлдвэрийн танхимаас тухайн үед 375 нэр төрлийн барааг бид экспортолно гэдэг ийм саналыг авсан байдаг. Мөн Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас яг энэ саналыг эцэслэж өгсөн байдаг юм. Ингээд энэ хэлэлцээр хийх ажлын хэсгийг анх Эдийн засаг, хөгжлийн дэд сайд ахлан хариуцаж байсан бөгөөд Монгол Улсын ЗГ-ын 2024 оны 44 дүгээр тэмдэглэлийн дагуу тус хэлэлцээрийг хийх Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах үүргийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад үүрэг болгосон гэдгийг та бүхэндээ хэлье.

ЗГ-ын шийдвэрийн дагуу хэлэлцээр хийх ажлын хэсгийг 2025 оны 1 дүгээр сард шинэчлэн зохион байгуулсан. Оны өмнө чуулган дээр асуудал өөрөөр хөндөгдсөн. Нэг үгээр хэлбэл хэлэлцээрт байгаа дотоодод үйлдвэрлэдэг буюу дотоодын масс үйлдвэрлэл олон жил зүтгэсэн энэ салбаруудыг хамгаал гэдэг энэ чиглэлээр Лодойсамбуу гишүүнээс эхлүүлээд олон гишүүд саналаа хэлсэн. Энэнтэй уялдуулаад тус ажлын хэсэг нь 2 хэсгээс бүрдсэн ийм ажлын хэсэг байгуулсан. Хэлэлцээрийн төслийн бичвэрийг эцэслэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД ахалж ажилласан. Гишүүдийн бүрэлдэхүүнд яамдын газрын дарга нарыг оролцуулан байгуулсан байдаг. Харин барааны жагсаалтад санал, зөвлөмж боловсруулах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ТНБД ахалж, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, холбогдох яамдын оролцоо бүхий 25 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Нэг үгээр хэлбэл тал талын төлөөллийг оролцуулж бараа, бүтээгдэхүүнийхээ хэлэлцээр дээр ажиллая гэж.

Барааны жагсаалтад санал боловсруулах дэд ажлын хэсгээс 25 оны 1 сарын 23-ны өдөр нийт 375 бараан дотроос 23 барааг тус хэлэлцээрийн Монголын тарифын үүрэг амлалтын жагсаалтаас хасуулах саналыг ирүүлсэн. Энэ хүрээнд нийт 3 удаа албан бичгээр санал солилцож, 1 удаа биечлэн хэлэлцээр хийж, гарсан үр дүнгээ та бүхэндээ танилцуулж байна. Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцоходоо Монгол Улсын талаас импортын нөлөөлөлд эмзэг тодорхой бараануудад айлын талаар буулт хийлгэсэн гэж ойлгож байгаа. Харилцан ашигтай тохиролцоонд хүрч чадсан. Монгол Улс энэ хэлэлцээрээр маш их ашиг хүртэнэ гэдэг ийм итгэлтэйгээр та бүхэндээ танилцуулж байгаа шүү. Хэлэлцээрийн хүрээнд 2 талаас ижил тооны буюу бараа тодорхойлох кодчиллын уялдуулсан системийн 6 оронтой кодоор 367 нэр төрлийн бараанд тарифыг шууд тэглэх, тариф бууруулах, тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх, тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх гэсэн үндсэн 4 төрлөөр тарифын саад тотгорыг бууруулахаар тохиролцлоо.

Мөн манай улсын стратегийн болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын нөлөөллийг бага байлгахад онцгойлон анхаарсан бөгөөд тоо хэмжээний хязгаарлалт тогтоох, зарим барааг хасуулах замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохицуулалтыг хэлэлцээрийн төсөлд тусгаж чадлаа. Тухайлбал өндөгний хувьд Монгол Улсын сүүлийн 3 жилийн дотоодын хэрэглээ жилд дунджаар 448,6 сая ширхэг байсан бөгөөд үүнээс 165 сая ширхэг буюу 36,8 хувийг импортоор нийлүүлсэн байна. Дотоодын өндөгний үйлдвэрлэлийн зах зээлийг хамгаалах зорилгоор өндөгний зах зээлийн 20 хувийг импортын орон зайнд үлдээсэн. 90 сая

ширхэг хүртэлх импортын өндөгний гаалийн татварыг 50 хувь бууруулж 7,5 хувь, харин 90 сая ширхгээс илүү өндөг импортлогдсон тохиолдолд гаалийн татвар 15 хувь хэвээр байхаар тохиролцлоо. Улаан буудайны хувьд манай улс жил бүр ургац хураалтын нөхцөл байдал, гурилын үйлдвэрлэлийн технологийн шаардлагаас шалтгаалаад 70 хүртэл мянган тонн улаан буудайг импортлох шаардлага үүсдэг юм байна. Айлын талаас хатуу болон зөөлөн улаан буудайд нийтэд нь 180 мянган тонны квот санал болгосон. Энэ бол хэлэлцээрийн сүүлийн мөч хүртэл энэ дээр 2 тал ярилцсан гэдгийг та бүхэндээ хэлмээр байна. Бид 50 мянган тонн хүртэлх хэмжээнд одоогийн татварын хэмжээг 1,25 нэгж хувиар бууруулж 3,75 хувийн татвар ноогдуулах бөгөөд 50 мянган тонноос дээш импортлогдсон хэмжээнд 5 хувийн татварыг хэвээр хадгалахаар тохиролцсон. Тэгэхдээ энэ 50 мянга бол квотоор олгогдож байгаа хэмжээ шүү гэдгийг та бүхэндээ хэлмээр байна.

Эдийн засгийн хэлэлцээр хийснээр Евразийн зах зээлд нийлүүлэх мах махан бүтээгдэхүүний экспортыг бид 125-аас 140 хувиар нэмэгдэхээр тооцогдож байна. Хувцас 84 хувь, ноос ноолуур 64 хувь, нэхмэл, сүлжмэл хувцас 55 хувь, арьс, ширэн эдлэл 46 хувь тус тус нэмэгдэх боломж харагдаж байна. Тэгэхдээ энэ бол мэдээж Монголын дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадвар, тэр хүмүүсийн гадаад худалдааны чадавхаас шууд хамааралтай гэдгийг бид тал талдаа ойлгох хэрэгтэй. Эдгээр зах зээлд Монголын бараа, бүтээгдэхүүн ийнхүү гаалийн татваргүй нэвтэрч чадсанаар зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвараа цаашид нэмэгдүүлэх өргөн боломж яг энэ салбар дээр хөрөнгө оруулалт татах боломжууд бий болох юм байна. Үүнийг тодотговол Евразийн эдийн засгийн холбооны улсуудын нийт хэрэглээ бус зөвхөн импортын хэмжээ нь л гэхэд 2023 оны байдлаар мах махан бүтээгдэхүүн дээр 700 сая долларын импортыг хийсэн байна. Арьс ширэн бүтээгдэхүүн дээр 6,9 тэрбум ам.долларын импортыг хийсэн байна. Ноос ноолуурын эдлэл дээр 7,5 тэрбум ам.долларын импортыг хийсэн байна. Ингээд харвал нийт 14, 15 орчим тэрбум ам.долларын импорт манай үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүнүүдийн хүрээнд тэр зах зээл рүү орсон байна гэдэг ийм тоо баримт байна.

Манай улсад хэрэгжүүлж байгаа Цагаан алт, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээнүүд идэвхтэй өнөөдөр хэрэгжиж явж байгаа. Өнөөдөр хэлэлцэж байгаа энэхүү хэлэлцээр нь дээр дурдсан төрөөс хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдээр бий болох суурь тогтолцоог бүрэн утгаар нь цаашаа хөгжүүлж, дотооддоо боловсруулах, экспортлох, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт, бизнесийн орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Улмаар хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэн нэмэгдэж, Монголын 250 мянган малчин өрхийн хаалгаар бодитой орлого ашиг очих учиртай. Энэхүү худалдааны түр хэлэлцээрийг байгуулснаар ААН-үүдийн экспортын зардал буурахаас гадна, худалдааны үйл ажиллагаа илүү нээлттэй болж, гадаад худалдаа эрхлэгчдэд нийтлэг тулгамддаг асуудлуудыг хөнгөвчилж хялбаршуулах юм.

Хэлэлцээрт туссан худалдааг хөнгөвчлөх онцлог зохицуулалтаас дурдвал зайлшгүй ашиглагддаг боловч дотооддоо бэлтгэн нийлүүлж чадахгүй байгаа гадаад улсын гаралтай орц, материалыг экспортлох барааны өртгийн 50 хүртэл хувь тооцуулах боломж бүрдүүлснээр илүү хялбараар экспортлох бараандаа тарифын чөлөөлөлт авах боломж бүрдэж байгаа. Гаалийн байгууллагууд 4 цагийн дотор худалдаа эрхлэгчид барааг олгож, худалдаа эрхлэгчдэд тулгардаг бодит саад

бэрхшээлийг бууруулж байгаа. Барааны гарал үүслийн гэрчилгээг хатуу шаардахгүйгээр 12 сарын дотор нөхөн гаргаж, тарифын хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлж байгаа. Бүх бараанд тавьдаг гаалийн шалгалтыг багасгаж, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхээр байгаа. 5 мянган еврогоос бага үнэтэй бараанд гарал үүслийн гэрчилгээ шаардахгүй болж жижиг, дунд бизнес, цахим худалдаа эрхлэгчдэд хялбар экспортын боломжийг бүрдүүлэх юм.

Иймд Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн нэгд заасны дагуу тус хэлэлцээрийг Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөн шийдвэрлэх тул асуудлыг та бүхэн шийдвэрлэж дэмжиж өгөхийг хүсье. Энэ удаагийн хэлэлцээр бол Япон энэ тэртэй хийсэн хэлэлцээрийн хажууд маш тийм бага орон зайнд хийгдэж байгаа гэдгийг манай гишүүд сайн ойлгоосой гэж бодож байгаа. Бид Япон руу экспортлох барааныхаа тоог жишээлбэл 9 мянгаар авч байсан бол одоо энэ дээр 367 бараа байгаа. Импортлох барааныхаа тоо хэмжээг 6 мянга хэдэн зуугаар авч байсан бол одоо импортлох бараа нь ч гэсэн 367 байгаа. Нэг үгээр хэлбэл түр гэрээг бага хэмжээтэй, бага хэмжээ гэдэг нь бараа, бүтээгдэхүүн яагаад ийм цөөхөн байна вэ гэхлээр бидний өрсөлдөх чадварын хэмжээнд энэ зах зээл рүү гэрээ хийгээд ажиллаад үзье, ажиллая гэдэг ийм хэлэлцээрийн төслийг та бүхэнд танилцуулж байгаа. Энэ бол олон жил манай үйлдвэрлэгчид хүсэн хүлээж байсан ийм хэлэлцээр байдаг:

Энэ удаа энийг цаг нь болно гэдэг зүйл болж байгаа болов уу гэж харагдаж байгаа юм. Энэ дээр цаг алдвал магадгүй энэ хаалга хаагдахаар байгаа. Энэ хаалгыг цаашаагаа нээгээд, худалдаагаа арвижуулаад явбал бидний хүсээд байгаа энэ эдийн засгийг төрөлжүүлэх, магадгүй яг бид хийдэггүй байж болно л доо. Гадаа яг ажил эрхэлж байгаа, амьдралаа залгуулж байгаа тэр 250 мянган малчин айлын орлого бодитойгоор бий болох, арьс ноос, дайвар бүтээгдэхүүн нь үнэд хүрэх ийм боломжийг бид гаргаж ирж байгаагаараа их онцлогтой юм шүү гэдгийг та бүхэндээ хэлмээр байна. Ингээд асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийг танилцуулъя. Лувсаннямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Анар Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга, Энх-Амгалан Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Баттуяа Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Нямбаяр Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн зөвлөх, Өлзийсайхан Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал, Соёлмаа ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ХХААХҮЯ-наас Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Дондогдорж Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, МҮХАҮТ-аас Төр-Од Ерөнхийлөгч, Адьяасүрэн Гадаад худалдаа, экспортыг дэмжих төвийн ахлах.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Цогтгэрэл гишүүнээр тасалъя. Номинчимэг гишүүн микрофоныг нээе.

О.Номинчимэг: Бүгдэд нь өнөөдрийн мэнд хүргэе. Өнөөдөр дэлхийн Эх дэлхийн өдөр, earth day. Тэгээд энэ өдрийг бид хүн болгон эх дэлхийгээ хайрлаж, ялангуяа эрчим хүчээ хэмнэх урианы дор өнгөрүүлдэг. Тэгээд бүгдэд нь энэ завшааныг далимдуулаад Эх дэлхийн өдрийг хүргэе. Өнөөдөр энэ эдийн засгийн

хэлэлцээрийн тухай бид өнгөрсөн долоо хоногоос нэлээн ярилаа. Би энэ ажлын хэсэгт суугаа хүмүүстээ ч гэсэн саналаа хэлээд яваад байгаа. Өчигдөр МАН-ын бүлгийн хурлын дараа мэдээлэл хийхдээ Хүнс, хөдөө аж ахуйн сайд Энхбаяр сайд маш хариуцлагагүй мэдээлэл хийж байна. Тэр юу вэ гэхээр би энэ өмнө нь өмнөх долоо хоногт дурдсан. Энэ тамхин бүтээгдэхүүн тамхийг гаалийн татвараас 30 хувийг нь чөлөөлчхөөд байгаа. Тэгээд хэлээд байгаа, та хэд эдийн засгаа харж л байгаа байх. Гэхдээ энэ тамхинаас шалтгаалсан хавдрын өвчлөл чинь нийт нас барж байгаа хүн амын 17 хувийг эзэлж байна. Жилд бүр 4300 хүн энэнээс болж нас барж байна. Тамхины хэрэглээнээс шалтгаалсан эдийн засгийн алдагдал чинь 801 тэрбум буюу манай ДНБ-ий 2,1 хувь гэж байна. Ийм их зардалтай эрүүл мэндийн зардалтай асуудал. Тэгээд энэ бүхнийгээ импортын тамхинаас хамааралтай энэ зах зээлээ яагаад хамгаалахгүй тамхин бүтээгдэхүүний энэ 5 улсаас нийт манай импортын зах зээлийн 35 хувь нь орж ирдэг гаалийн татварын 30 хувиа тэглэхээд байна вэ?

Тэгээд онцгой татвараа нэмчихнэ гээд байгаа юм. Энэ боломжгүй. Та бүхэн бид Сангийн сайдтай ч гэсэн Сангийн яамныхантай ярьсан. 5 улсаас орж ирж байгаа тамхин дээр 10 төгрөг, нөгөөдүүл дээр нь 7 төгрөг байя гэдэг онцгой татварыг ялгамжтай тавьж болохгүй шүү дээ. Тэгээд энэ асуудлаа ингээд цэгцлээд ороод ирээч гэдгийг удаа дараа хэлж байгаа. Тэгэхээр энэ тамхиа дахиад энийгээ хасах тал дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эдийн засгийн яам гол оройлон ажиллаж байгаа negotiation хийж байгаа. Энийг дахиад нэг их яриад энийгээ хасах боломж байна уу? Хасахгүй бол энийг би дэмжих боломжгүй гэдгээ хэлж байгаа. Энэ дээр дахиад negotiation хийгээд, тэр олон улсын Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенцоо бариад хасах боломж байгаа үгүй юү гэдэг дээр та бүхэн нэг тодорхой хариу хэлээдхээч.

Л.Соронзонболд: Хэн хариулах вэ? Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Энэ хэлэлцээрээс хасах бараа бүтээгдэхүүнийхээ жагсаалтыг бид нөгөө Хүнс, хөдөө аж ахуйн яам, мөн Аж үйлдвэрийн танхим гээд хэрэглэгч, үйлдвэрлэгч талаасаа саналаа авдаг. Яг авсан саналынхаа дагуу асуудлаа тавьсан. Номинчимэг гишүүнтэй санал нэг байгаа. Тамхин дээрээ бид илүү татвар авах хэрэгтэй. Тийм учраас нэгдсэн байдлаар тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлнэ гэсэн ийм ойлголттой байна. Бидний зүгээс тамхиа жагсаалтаас хасъя гэдэг саналыг хүргүүлсэн. Зүгээр бодит байдал дээр энэ жил Евразийн эдийн засгийн холбоог Казакстан улс тэргүүлж байгаа. Тэгээд Казакстан улс Монголтой хийж байгаа худалдаан дотор тамхи нь бараг их өндөр хувийг эзэлдэг юм байна. Тийм учраас аль ч улс нь одоо бид энэ зах зээл рүү бараагаа заръя гэж тэмүүлж байгаатай яг адилхан утгаар аль ч улс нь өөрийнхөө зарж чадах бараагаа хамгаалаад ингээд хамгаалаад байгаа. Энийг аль нэг 5 улсаас аль нэгийг нь сугалаад хэлэлцээр хийх боломжгүй. Яг бүгдээрээ тэнцүү эрхтэй байдаг хэлэлцээрт орж байгаа улсууд. Тийм учраас яг энэ саналыг авахгүй байгаад байгаа юм. Бид тавьж байгаа. Өнөөдөр Эдийн засгийн байнгын хороогоор тамхийг энэ жагсаалтаас хас гэдэг зөвлөмж гарвал бид цаашаагаа энэ хэлэлцээрээ ийм зөвлөмж гарлаа. Тийм учраас энэ жагсаалтаас хасъя гэдэг энэ байдлаар асуудлаа дахиад л тавиад явна.

Л.Соронзонболд: Номинчимэг гишүүнд микрофон нээе.

О.Номинчимэг: Тэгээд энэ нийтийн эрүүл мэндийн онцгой татвартай бүтээгдэхүүнийг ерөнхийдөө олон улсын гэрээ хэлэлцээр энэ тарифыг бууруулах тал дээр битгий авч үзээч гэдэг энэ тамхины суурь конвенцод бид нэгдээд орчихсон, бид үүрэгтэй, энэ конвенцыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэгээд анхнаасаа энэ хэлэлцээрийг би Эдийн засаг, хөгжлийн яамныханд хэлмээр байгаа юм. Хүнс, хөдөө аж ахуйн яам нь болохоор бид нэг дотоодын бүтээгдэхүүнээ хамгаална гээд өгчихсөн гээд импортоо бодсон ч юм уу, үгүй ч юм уу? Тэгээд Гадаад хэргийн яаман дээр энэ олон гэрээ конвенцын хэрэгжилтийн асуудал явж байдаг. Тэд нартаа листээ үзүүлэхгүй. Тэгээд ингээд нөгөө бодлогын түвшинд уялдаа холбоотой ажиллахгүй байхаар зөвхөн хэдэн бараа, үйлчилгээний тариф, хязгаарлалт, квот дээр төвлөрөөд, бусад том юмаа ерөөсөө та бүхэн хараагүй байна шүү. Тэгэхээр энэ дээр Эдийн засгийн байнгын хорооноос зөвлөмж гаргаасай гэж бодож байна. Бид энэ тамхины гаалийн 30 хувийн татварыг гаалийн татваргүй болгоно гэж нэг улсын шахалтаар энэ гэрээнд оруулж болохгүй. 3 жилийн түр хэлэлцээр гэж байгаа боловч та бүхэн сая сонсож байна. Тамхины хэрэглээнээс шалтгаалсан манай эдийн засгийн алдагдал 801 тэрбум гэж.../минут дуусав/

Л.Соронзонболд: Нэмэлт минут авах юм уу? Номинчимэг гишүүнд нэмэлт нэг минут өгье.

О.Номинчимэг: Тэгээд нийтийн эрүүл мэндийг хамгаалах гэдэг чиглэлээрээ энэ тал дээр бүгдээрэнг нь тооцооллоо хийгээд, тамхидалтаа бууруулах энэ онцгой албан татварын тооцоолол Сангийн яам хийгээд явж байтал одоо ингээд зах зээлийн 35 хувь дээр нь ялгаатай татварын бодлого ороод ирвэл энэ өөрөө зах зээлд импортлогчдын хувьд ч гэсэн тэгш бус байдал. Дараа нь энэ дээр Монгол Улс ч гэсэн нийтийн эрүүл мэндийг хамгаалах татварын бодлогоо хэрэгжүүлэхэд ч гэсэн учир дутагдалтай ийм зүйл болох гээд байна. Тэгэхээр энэ дээр Эдийн засгийн байнгын хорооноос энэ зөвлөмжийг заавал гаргаж өгөөч гэж хүсэж байна.

Л.Соронзонболд: Номинчимэг гишүүн санал хэллээ зөвлөмж гаргах. Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Энэ аж үйлдвэрлэлийн хөгжил, хөдөө аж ахуйн хөгжил, газар тариалангийн хөгжил эрс тэс өөр л дөө. Бидний тэр Казахстан гэдэг юм уу, ОХУ. Энэ дээр нэг жоохон бодох л хэрэгтэй дээ. Энэ үгнүүдийн цаана юу байгаа вэ гэдгийг Гантөмөр сайд ойлгож л байгаа байх. Сайн ойлгож байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхдээ бизнесийн суурь хэрэгтэй л дээ. Дан улс төрийн гэхээсээ илүү. Энэ дээр нэг тийм харилцан шал өөр нөхцөл байдалтай шүү гэдгийг сайн бодолцсон юм байгаа биз дээ? Дөнгөж тэнцэж ядаж байгаа хүмүүс чинь тэгээд сөхрөөд унах вий дээ. Европын холбоонд элссэн олон улсуудаас ганцхан Польш улс л амжилттай яваа. Бусад бүх үйлдвэрүүд сөхөрсөн бусад улсын. Энийг мэдэж байгаа байх гэж би бодож байна. Тэгээд энийгээ сайн олж харсан юм байлгүй дээ. Яривал зөндөө зүйл байна л даа. Ямар, ямар бүтээгдэхүүнүүд дээр бид сул хөгжилтэй билээ, өрсөлдөх чадваргүй билээ гэдгийг ойлгож байгаа байх гэж бодож байна.

Нэгэнт Эдийн засгийн сайд байгаа учраас би тэр Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга байгаа учраас нэг зүйл хэлээдэхье. Эдийн засгийн сайд энэ топ 100, топ 100 гээд яриад байдаг болчихсон байна лээ. Тэр топ 100 ААН чинь Монгол Улсад хамгийн өндөр татвар төлдөг компаниуд биш шүү дээ. Тэр чинь шал өөр байдаг юм шүү. Энийг наад эдийн засгийн хэлэлцээртээ сайн анхаарч байх хэрэгтэй шүү. Танд яаж танилцуулдаг юм. Ер нь энэ топ 100 ААН гэдгийг ард түмэн ойлгохдоо

Монгол Улсад хамгийн том татвар төлдөг л гэж ойлгодог юм шиг байгаа юм. Гэхдээ би бол ийм үзүүлэлт тэнд байхгүй шүү. 30 хувьд нь байгаа байх бүгдийг нь үгүйсгээд яах вэ. Тэгээд энийг Эдийн засгийн сайд анзаарч байх хэрэгтэй. Ер нь ЗГ анзаарч байх хэрэгтэй шүү энийг. Тэгээд ялангуяа өсөж байгаа жижиг, дундуудаа сайн анхаарч байх хэрэгтэй. Тэгэхгүй бол топ 100, топ 100 гэдгээр биш. Зарим компаниуд хүртэл энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимд чинь байдаггүй юм шүү дээ элсдэггүй, ордоггүй. Тэгэхлээр энийг анхаарах хэрэгтэй. Тэгээд ер нь тэгээд яах вэ бүлэг нэгэнт л шийдвэрээ гаргасан учраас би зүгээр байр суурь өөр байсан ч гэсэн дэмжээд явна. Ер нь яах вэ зарчимтай л даа. Тэгээд тэр зарчмаа барина. Гэхдээ энэ дотор засаж залруулах зүйлүүд зөндөө байгаа. Та түрүүн хэллээ. Нэлээн удаан хүлээсэн гээд. Миний хувьд жоохон хүлээх хэрэгтэй байсан болов уу гэж би бодож байгаа. Арай л түргэдчихсэн болов уу л гэсэн бодол байна. Зүгээр яах вэ цаг хугацаа харуулна биз дээ. Баярлалаа.

Л.Соронзонболд: Ганбаатар гишүүн санал хэллээ. Гантөмөр сайд хариулах уу? Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Ганбаатар гишүүний болгоомжлолыг бид бүх түвшинд харж байгаа. Гол нь зүгээр би цаг нь өнөөдөр момент байх гэж байгаа нь манай зах зээл өөрөө 3 сая, 3,5 сая хүнтэй зах зээл байдаг. Нөгөө зах зээл маань 200 сая хүнтэй зах зээл байдаг. Тэгээд 200 сая хүнтэй зах зээлийн болгоомжлох зүйл юу вэ гэхлээр өөрийнхөө зах зээлийг нээгээд өгчихөөр нөгөө цөөхөн хүнтэй газар нь гаднын хөрөнгө оруулалт орж ирээд, төрөл бүрийн үйлдвэрлэл хөгжөөд, тэр бараа, бүтээгдэхүүн асар их хэмжээгээр тухайн улс руу худалдаалагддаг ийм л юутай шүү дээ, ийм л урсгалтай. Трамп их өндөр тариф тавиад байгаа шалтгаан ОХУ болоод бусад энэ улсууд Монгол Улсад яг ийм байдлаар өндөр тариф тавьсан. Трампын тариф өндөр тавьж байгаа шалтгаан жишээлбэл Америкийн зах зээл байхгүй бол Мексикт үйлдвэрлэл хөгжихгүй л гэж байгаа юм. Америкийн зах зээл байхгүй бол Канадад хөгжихгүй л гэж байгаа юм. Яг түүн шиг манай хойд хөрш бол зах зээлээ өгөхгүй тохиолдолд Монголд үйлдвэрлэл ерөөсөө хөгжихгүй. Хятад улс манайд зах зээлээ өгөхгүй, хойд талд зах зээлээ өгөхгүй. Ингээд бид 3 сая хүнтэй, монопол цөөхөн компанитай, хэдэн банкны мөнгийг хүүлдэг ажилтай. Яг өнөөдрийн энэ доголлон эдийн засаг цаашаагаа асар хурдтайгаар биежнэ.

Өнөөдөр жишээлбэл банк бус санхүүгийн байгууллагууд ломбардаас зээл аваад зээл өгөөд байна шүү дээ. Ломбардаас 200, 300 тэрбум долларын зээлийг банк бус нь зээлээд, цаашаагаа зээлээд сууж байна. Нэг үгээр хэлбэл манай зах зээл юу болсон бэ гэхлээр хэдэн монополоо тэжээдэг, тэгээд нэг тийм картель маягийн сүлжээ рүү орчихсон. Доороос хүн босож ирж болдоггүй, 250 мянган малчны амьдрал ерөөсөө сайжирдаггүй, орлого нь нэмэгддэггүй. Яагаад вэ гэхлээр том зах зээл байхгүй болохоор ерөөсөө нийлүүлэлт тал чинь болохгүй байна л гэдэг зүйлийг олон жил ярьсан учраас Урт хугацааны хөгжлийн бодлогодоо эрдэмтэн мэргэд маань олон талаас нь бодож энийг оруулсан байдаг юм байна лээ. Тийм учраас бид үүрэгтэй, хийх үүрэгтэй, үүргээ биелүүлээд оруулж ирж байгаа шүү гишүүнээ.

Ер нь энэ дайн байлдаан нь дуусах үед бид нар луу бараг харахгүй дээ. Энэ зах зээлээс өөрсдийгөө л хамгаалах гэж оролдох байх. Ер нь Казакстан улсын хөгжлийг хараад байхад ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр хийснийхээ үр дүнд маш том эдийн засагтай болсон, маш их гаднын хөрөнгө оруулалтыг татсан, бараа, бүтээгдэхүүнээ хажуу дахь том орон зай руугаа экспортолж чадсан ийм зүйл

ажиглагдаад бодитой байгаад байна. Тийм учраас гишүүд минь гарч байгаа боломжийг хэдүүлээ айхгүйгээр ашиглах нь зөв гэж хэлж байгаа юм. Ингээд жоохон дэлгэрэнгүй ярихгүй бол маш их буруу ойлголт гадуур тарж байна. Евразийн холбоонд элсэж байгаа юм шигээр ярьж байна, бид энэ холбоонд элсэхгүй. Ажиглагч гишүүнээр орж байгаа юм шиг ярьж байна, бид ажиглагчаар ч орохгүй. Бид энэ зах зээл рүү өөрийнхөө өнөөдөр үйлдвэрлэж чадаж байгаа бололцоотой үйлдвэрлэл ялангуяа хөдөө аж ахуй, тэр дундаа МАА-гаа дэмжсэн үйлдвэрлэлийг бодитой нэг эдийн засаг болгоод авъя л гэж байгаа юм.

Л.Соронзонболд: Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Би нэг хэлээ хазаад өнгөрчихье гэж бодсон юм. Тэгэхдээ та хариулсан учраас хариулъя даа, ярья даа. Япон дээр яг та нар хуу хариулж байсан юм л даа. Та тэр үед гишүүн биш байсан. Өнөөдөр Япон хэдэн ямар зах зээлтэй өнөөдөр Монгол ямар байна, хэдэн барааны жагсаалтууд гарсан билээ, өнөөдөр яаж амжилтад хүрч байна. Эдийн засгийн сайд мэдэж байгаа байх. Би энэ дээр чинь зүгээр анхааруулж хэлж байгаа юм. Энийгээ сайн анзаараарай. 200 сая хүнтэй гэхлээрээ л мундаг болчихдог юм биш. Та Японыг эргээд наад хүмүүсээсээ асуугаарай. Хаана нь бид юугаараа алдав? Ямар бараа, бүтээгдэхүүн Япон руу экспортолж байна вэ? Энэ чинь нэлээн том дохио шүү. Тэгээд яах вэ таны та бид 2 бараг нэг юмыг 2 талаас нь ярьчих шиг боллоо. Тийм. Тэгэхдээ нэг зүйл хэлэхэд яах вэ цаг хугацаа харуулах байх. Та үнэхээр яг та ХАА-н салбар хөгжих нь үү, үгүй юу гэдгийг. Энийг яах вэ харна биз дээ, 1 жил, 2 жилийн дараа.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гантөмөр сайд хариулах юм уу? Найдалаа гишүүний микрофоныг нээе.

Б.Найдалаа: Энэ Евразийн холбооны хэлэлцээрт төр нэгдэх тухай асуудал нэлээн маргаантай байгаад байгаа юм. Тэгээд ХҮН намын зөвлөл дээр өчигдөр танилцуулга сонссон. Нэлээн сайн судалгааг нь үзсэн. Зүгээр том зургаараа дэнслээд үзвэл Монгол Улс энэ хэлэлцээрт түр хугацаагаар нэгдэх нь зайлшгүй зөв байна. Монгол Улс хоёрхон хөрштэй. Урд хөрштэйгөө гол харилцаагаа хийж байгаа эдийн засгийн. Хойд хөрш болон баруун хөршүүдтэйгээ огт хийдэггүй. Тэгээд эдийн засаг хөгжих, улс хөгжихийн хамгийн эхний суурь ердөөсөө л зах зээл шүү дээ. Тэгээд тэр зах зээлийг нээх, нээхгүй хоёрхон сонголт бид нарт байгаа. Нээхгүй гээд суугаад байвал ямар ч утга учир байхгүй. Тэгэхээр энэ дээр зарчмын бодлогын хувьд Монгол Улсын хувьд заавал зөвхөн Еврази ч биш, Америк байна уу, Япон байна уу бүх зах зээлийг нээх ёстой. Энэ дээр хатуу байр суурьтай байна.

2 дугаарт нь яах вэ энэ хэлцлийн хүрээнд 8 бүтээгдэхүүнийг хасчихсан юм байна. Нөгөө эмзэг эмзэглээд байгаа алдчих вий гээд байгаа гол нэрийн бараануудаа хамгаалчихсан юм байна л даа. Тийм болохоор тодорхой хэмжээгээр эрсдэл багассан байна. Хамгийн гол нь би гишүүдийг болон бусад хүмүүсийг ингээд бодоосой гэж бодоод байгаа юм. Зах зээлээ нээж байж Монгол Улс бэлэн байдалд орно уу гэхээс биш бэлэн болчихоод туузаа хайчлаад дараа нь зах зээлээ нээдэг юм хаана ч байхгүй. Зах зээлээ дагаж үйлдвэрлэнэ, зах зээлээ дагаж хөрөнгө оруулалт нь явах болохоор яах аргагүй эхлээд нь зах зээлээ нээж байж нөгөө бизнес эрхлэх, хөрөнгө оруулах сэдэл нь төрөх юм. Энэ нь ч судалгаагаар харагдаж байна лээ. Тэгэхээр энэ бол бодитой зөв алхам гэдэгт эргэлзэхгүй байгаа юм. Зах зээлээ нээгээгүй байхад хэн жишээлбэл арьс элдээд, үхэр үржүүлээд мах зарах гээд суух билээ. Тэгэхээр заавал энэ хэлэлцээр байж дараагийн бизнес хөрөнгө оруулалтын

дохио эхэлнэ. Тэгээд яах вэ богино хугацаанд ингээд шууд үр дүн гарахгүй байж магадгүй. Гэхдээ ямар ч байсан дунд хугацаанд шинээр ХАА-н ч юм уу, түүхий эд дээр суурилсан үйлдвэрлэл, бизнес, экспортод чиглэсэн бизнесийн ямар ч байсан сэдэл төрнө гэж бодож байгаа юм. Тэгээд энэ зөв гэж бодож байгаа юм.

Энэ дээр харин нэг асуулт байна. Хамгийн чухал зүйлийг бид орхигдуулаад байгаа юм. Яг үнэндээ Монгол Улс энэ хэлэлцээрээс үр дүнтэй байх эсэх нь энэ хэлэлцээрээс биш, Евразиаас биш, Казакстанаас биш, Оросоос биш бид нараас хамаарах байхгүй юу бид нараас. Жишээ нь би асуулт энэ байна л даа. Тэр яг энэ зарим жижиг улсууд энэ Евразийн хэлцэлд ороод алдсан гэж жишээ яриад байгаа юм. Тэр алдсан улсууд бол тэр Евразиаас болоогүй, зах зээлээс болоогүй, тарифаас болоогүй өөрсдийнх нь бизнесийн орчин байхгүйтэй л байхгүй юу. Өөрсдөө гэрийн даалгавар хийж чадахгүй байгаа юм. Тэгээд миний асуулт бол одоо энэ ингээд хэлэлцээд ороход болно, болж байна. Яг Японтой адилхан, бусад улсуудтай адилхан зах зээлээ нээчихлээ. Монгол Улс хэлэлцээртэй холбоогүйгээр бизнесийн орчныг таатай болгох, татварыг нь багасгах, нөгөө бүртгэл тооцоо, зөвшөөрлийг нь багасгах. Ер нь зүгээр Улаанбаатарт ч байна уу, Орост ч байна уу, Казакстанд ч байна уу, Японд ч байна уу тэр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зориулсан тэр бизнесийн орчныг сайжруулах талаар ямар алхам хийх юм бэ дорвитой, энэнээс хамааралгүйгээр, ер нь суурь байнгын хийх гээд байгаа тэрэнд нэг хариулж өгөөч.

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: 3 зүйл байгаа. Яг Найдалаа гишүүний хэлж байгаа энэ бизнес эрхлэх бололцоог нь бий болгооч гэдэг зүйл дээр бид яг бизнесийнх нь тулгамдаж байгаа бэрхшээлүүдийг арилгах бүрэн хэмжээний төлөвлөгөө гаргаад ажиллаж байгаа юм. Энгийг бид энэ жилдээ багтаагаад нэлээн олон ажлуудыг хийчихнэ гэж бодож байгаа. Наад зах нь компани бүртгүүлэх, компани татан буулгах, татварын хураан, татвар хураахтай холбоотой бодлого гэх мэтчилэн. Ер нь бизнес эрхлэх орчноо сайжруулахгүйгээр Монголын бизнес эрхлэх, үйлдвэрлэл эрхлэх, худалдаа эрхлэх энэ орчин сайжрахгүй юм байна лээ. Энэ дээр санал нэг байна 1 дүгээрт.

2 дугаарт экспортыг дэмжих энэ үйлдвэрлэл дээр гарцаагүй санхүүгийн дэмжлэг хэрэгтэй юм байна лээ. Тэгэхгүй дангаараа мөнгөө гаргаад, бараагаа аваачаад, гадаад улсад байршуулаад зарагдахыг нь хүлээгээд суудаг ийм эдийн засгийн чадавхтай үйлдвэрлэгч байхгүйтэй холбоотойгоор энэ зах зээл рүү манайхан гарч чадахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр бид Хөгжлийн банкныг Эксим банк болгоод яг тодорхой онилсон экспортлогчдыг бид хөрөнгө оруулалтын хэлбэрээр дэмжээд явах ийм шаардлага үүсэж байгаа.

3 дугаарт бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо маань алдагдсан нэг ийм зүйл байгаад байгаа юм. Хуучнаар уг нь ченжүүд. Ченжүүд бол уг нь их сайн ажилласан. Сүүлийн үед буцаж тэр нь задраад малчин болгон нийлүүлэгч болох маягтай ийм зүйл рүү орсон байдаг. Тийм учраас бид энэ нэг бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, дээр нь тэр логистикууд байгуулагдаж тэр лүү хөрөнгө оруулалт хийж байгаа хүмүүстээ төр, хувийн хэвшлийн түншлэлийг хийх боломжийг гаргаж ирье гэж байгаа юм. Тендер, удахгүй Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль орж ирнэ. Энэ дээр 1 төрлийн түншлэл нэмэгдэнэ. Тэр нь ЗГ хөрөнгө оруулалт хийгээд хамтарч болдог, менежментэд нь оролцдоггүй, бодлогоор дэмжлэг үзүүлдэг. Ингэж байж нөгөө малчдаас авдаг түүхий эд маань нөгөө ченж гэж яригдаж байгаа энэ логистик дээрээ ирээд, тэндээс хүртэх ашгийн ноогдол ашиг нь буцаад малчид руугаа очдог.

Магадгүй яг энийг цугларсан бүтээгдэхүүнийг дахиад үйлдвэрлэл рүү шилжихэд тэр түүхий эдийнх нь үйлдвэрлэл дээр нь дахиж хөрөнгө оруулаад, тэндээс ирж байгаа ноогдол ашиг дахиад малчид руу очдог ийм яг анхан нөгөө шатны бэлтгэн нийлүүлэгчид рүүгээ бодитой ашиг нь очиж байж энэ бизнес өөрөө урт хугацаандаа маш тогтвортойгоор орших л юм байна лээ.

Тэгэхгүй бол нэг зуднаар малаа алдаад л хөдөө аж ахуйн салбар 20 хувь унадаг, дараа жил нь зуд гайгүй болохоор 10 хувь өсдөг ч юм уу ийм савлагаатай байгаад байвал манай бүтээгдэхүүн өрсөлдөж чадахгүй байна гэж. Тийм учраас Найдалаа гишүүний хэлж байгаатай холбоотой яг ийм 3 бодитой төслийг бид маш богино хугацаанд хэрэгжүүлнэ. Тэгээд түрүүчийн тэр Япон дээр алдчихсан алдаанууд юу вэ гэвэл үнэхээр хийсэн гэрээнийхээ араас яваагүй, дэмжлэг үзүүлээгүй, бодитой шийдэл гаргаагүй, бодитой хөрөнгө оруулалтын орчин бүрдүүлээгүй, бодитой бизнесийн орчин бүрдүүлээгүй ийм алдаанууд бидэнд байна. Тийм учраас энэ алдааг давтахгүйгээр энэ богино хугацаанд бид амжилттай ажиллах шаардлага байна л гэж харж байгаа. Баярлалаа.

Л.Соронзонболд: Найдалаа гишүүн тодруулъя.

Б.Найдалаа: Тодруулаад саналаа хэлье. Тэгэхээр бид нэг юмыг яг маш сайн ойлгох хэрэгтэй байгаад байгаа юм. Асуудалд яг энэ хэлэлцээрээс хамаарах юм шиг, Японоос хамаарах юм шиг, Оросоос хамаарах юм шиг, Хятадаас хамаарах юм шиг яриад байгаа юм. Тэгээд хоорондоо маргалдаад байгаа юм. Яг үнэндээ бараа үйлдвэрлээд, бүтээгдэхүүн үйлдвэрлээд экспортлох, Улаанбаатарын зах зээл дээр зарах, Японд зарах, Орост зарах, Хятадад зарах яг адилхан. Ганцхан бид тэр бараагаа хийж чадахгүй, бизнес хийх, худалдаа хийх орчин нөхцөл нь таагүй байгаа болохоор бид чадахгүй байгаа болохоос биш энэ хэлэлцээрт нэгдсэн, нэгдэхгүйгээс болоод Монгол Улс муудчихаад байгаа юм ер биш. Тийм болохоор бизнесийн орчныг сайжруулах, аль улс, аль зах зээлд хамаарахгүйгээр чадавхаа нэмж чадвал, үгүй ээ ядах нь Улаанбаатарын зах зээл дээр дотоодын үйлдвэрлэл илүү хөгжих нөхцөлийг бүрдүүлж чадвал энэ хэлэлцээрээс үр дүн авна. Тийм болохоор гол анхаарах зүйл бусдаас нөхцөлөөс хамаарах биш, өөр.../минут дуусав/

Л.Соронзонболд: Нэмэлт 1 минут өгье.

Б.Найдалаа: Хариултаа авчихсан. Гол нь бусдаас биш, яг энэ өөрсдийнхөө бизнесийн орчин татвар, тэр нийгмийн даатгал, зөвшөөрөл, өөр авлига, юу гэдэг юм бизнес хийхэд саадтай бүх зүйлийг зоригтой арилгаж чадвал бид Евразийн зах зээл байтугай Орос, Хятадын зах зээл, Япон, Америк руу ч гарч чадах юм. Тэгээд энэ дээрээ гол анхаарлаа хандуулмаар байна.

Л.Соронзонболд: Найдалаа гишүүн санал хэллээ. Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Шинэ зах зээл нээх тухай яригдаад явж байгаа энэ асуудлыг зарчмын хувьд үгүйсгэх боломжгүй. Нөгөө талдаа аливаа эдийн засгийн шийдвэр, эдийн засгийн ч гэлтгүй бүх шийдвэрүүдэд цаг хугацаа тэр момент мөн үү, биш үү, бэлэн байгаа юу гэдэг асуудалд бид заавал энэнд хариулах ёстой. Тэгэхээр энэ Евразийн хэлэлцээр түр хэлэлцээр гэж байгаа юм 3 жилийн хугацаатай. Түр гэдэг чинь туршилт хийж үзэх юм байна туршилт хийж. Тэгэхээр энэ бодит байдлыг бид хөрштэйгөө болоод, гуравдагч хөршийн орнуудтай хийчихсэн бэлээхэн туршилтууд бид нарт байна ойрын жилүүдийн. Тэгэхээр Япон улстай бид 16 оны 6 сарын 1-нээс

байна уу эхэлсэн чөлөөт худалдааны хэлэлцээр үргэлжилж байгаа. Энэний үр дүнгийн дүгнэлт маш их тийм сонирхолтой байгаа юм. Энэ яг яагаад хангалттай биш байгаа юм бэ, энэ дээр ер нь ямар дүгнэлттэй байгаа юм бэ гэдэг асуудал асуултад бид хариулт өгөх ёстой.

Европын холбоотой Монгол Улс Европын холбоо руу 7200 бараа гаргана гээд арваад жил болж байна. Энэний дүгнэлт. Мөн нэг жилийн хугацаанд ОХУ-аас гурил, малын тэжээл импортолно чөлөөлнө гээд чөлөөлсөн эдгээрийн дүгнэлт. Тэгэхээр энэ дүгнэлтүүдээс үнэхээр яг татварын асуудал бид нарт эдийн засгийн түлхэц авчрах гээд байна уу, өөр шалтгаан байсан уу гэдэгт дүгнэлт хийх хэрэгтэй гэж миний хувьд бодож байгаа юм. Ингээд хэдэн тоо харахлаар би та нарт энэ слайд харуулъя. Энэ Японтой хийсэн Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр сүүлийн 10 жилээр нь ингээд үзэхэд 10 жилийн хугацаанд Монгол Улс Япон улс руу 24 сая долларын экспорт хийж байсан бол өнөөдөр 12 сая долларын экспорт хийж байна. Экспорт нь 2 дахин буучихсан бид чөлөөт худалдааны хэлэлцээр хийсэн. Япон улс манайх руу 367 сая долларын импорт хийж байсан бол одоо 1,1 тэрбум. Тухайн үедээ 10 жилийн өмнө 15-ыг харьцах нь 1 гэдэг харьцаатай худалдаа манай 2 орон хийж байж. 2 тал чөлөөт худалдааны хэлэлцээр хийснээс ингээд тооцохоор 93-ыг харьцах нь 1 гэдэг харьцаатай болчихсон. Чөлөөт худалдааны хэлэлцээр хийгээд 15-ыг харьцах нь 1 байсан бол 93-ыг харьцах нь 1 гээд зургаа дахин ашиггүй болчихсон. Бодит нөхцөл байдал ийм л байна.

Европ Европын холбоотой 7 мянган барааны хэлэлцээрийг манайх хийсэн. Тухайн үед манайх 104 сая долларын бараа гаргадаг байж. Одоо 101 сая долларын барааг өнгөрсөн жил гаргасан юм байна буурчихсан чөлөөт худалдааны хэлэлцээр, к... хөтөлбөртэй. Тухайн үед Европын холбооноос манайх руу 450 сая долларын импорт хийж байсан бол өнөөдөр 943 сая долларын импорт хийж байна. Чөлөөт худалдааны хэлэлцээр хийсэн чинь манайх 4-ийг харьцах нь 1 байсан чинь 9-ийг харьцах нь 1 болоод хувирчихсан. Нөхцөл байдал бид чөлөөт худалдааны хэлэлцээр 2 холын оронтой хийгээд ийм байдалтай. ОХУ-тай нэг жилийн хугацаанд.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гүйцээгээд асууя.

О.Цогтгэрэл: ОХУ-тай гурил дээр чөлөөлсөн. Дотоодын ХАА-н үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, малын тэжээлийн үйлдвэрлэл нэг жилийн хугацаанд 40 хувиар буурах ийм нөхцөл байдал үүсчхээд байна. Тэгэхлээр эндээс гарч байгаа асуулт нь, эндээс гарч байгаа асуулт ер нь манай бүтээгдэхүүнийг Японы зах зээл рүү орох болсон чинь үнэтэйдээд, үнэтэй болчихоод байсан юм уу аль эсвэл өөр шалтгаан, стандарт, чанар, гарал үүсэл, хорио цээр Европын холбоо руу эдгээрийг хангахгүйгээсээ болоод шалтгаан нь эндээ байсан юм биш үү? Түүнээс татварын 15, 10, 20 хувийн татвар дээр очоод уначихсан гэхэд энэ тоонууд чинь дэндүү харамсалтай тоонууд. 15-ыг харьцах нь 1 гэсэн худалдаа чөлөөт худалдааны өмнө хийдэг байсан чинь Чөлөөт худалдааны хэлэлцээрийн дараа 93-ыг харьцах нь 1 гэдэг ийм л үр дүн ингээд гарчихсан. Тэгэхээр эндээс гүйцээгээд асуухад энэ харьцаа өнөөдөр энэ хэлэлцээрийн дараа хэд болох юм бэ? ОХУ-тай 96-г харьцах нь 4 харьцаа энэ.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Тийм ер нь чөлөөт худалдааны хэлэлцээр хийгээд, тэрийгээ амжилттай хэрэгжүүлж байгаа улсууд юу хийж байна вэ гэхлээр Аж үйлдвэрийн парк 1 дүгээрт байгуулж байна, эрх зүйн орчныг нь өгч байна. 2 дугаарт чөлөөт бүсүүдээ их сайн хөгжүүлж байна. Монгол Улс маань нөгөө аж үйлдвэрийн парк, чөлөөт бүс гэдэг ойлголтоо бодитойгоор хийдэггүй, чөлөөт бүсээ нэг хил дээр байдаг орон зайг хараад байдаг. Бусад энэ чөлөөт худалдааны гэрээ хийхээд тийшээгээ бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлээд гаргаж байгаа улсууд бол өрсөлдөх чадварыг бий болгохын тулд гадна, дотнын технологи болоод бусад зүйл рүү аягүй хурдтай явж байна л даа. Явах арга нь юу вэ гэхлээр татваргүй орчин бүрдүүлж өгч байж тэр бараанууд нь цаашаагаа өрсөлдөөнд ялж байна. Японоор та бүхэн аягүй их жишээ авч байгаа. Ер нь Япон зүгээр яагаад худалдаа нь ихэсчихсэн юм бэ гэвэл машиныг нь л авч байгаа. Тэгээд та нар, бид бүгдээрээ л харж байгаа шүү дээ. Япон машин л бүгдээрээ унаж байгаа. Улаанбаатараар дүүрэн Япон машинтай болсон. Энэ хэлэлцээрийн үр дүнд Солонгос машин харагдахаа больсон, зарагдах нь эрс багассан.

Бидний харж байгаагаар өнөөдөр 3 тэрбум долларын бараа Евразийн бүсээс авч байна. Зөрүүлээд бид 100 сая долларын бараа худалдаж байна уу даа. Тэгэхээр бидний хүсээд байгаа зүйл бол энэ зах зээл өөрөө манай хэрэглэгчид манай өрсөлдөх чадварын хэмжээнд бид нараас арай алсарчхаагүй зах зээл байна гэж зүгээр амьдрал дээр харж байгаа юм. Тэгэхээр бид нарын мах борлуулах боломж энэ дээр гарах юм байна. Жишээ нь Япон хэзээ ч Монголын махыг авахгүй, авдаггүй. Монголын байтугай улсын махыг оруулдаггүй. 1 үгээр хэлбэл хорио цээрийн асар өндөр түвшний хамгаалалттай 1. 2 дугаарт гарал үүсэл гэдэг нэг зүйл байдаг. Энэ дээрээ Японтой хийхдээ хөрөнгө оруулагчид Монголд орж ирээд үйлдвэрлээд гаргадаг энэ процесс дээр бид өөрийн гэсэн орон зайг авч үлдээгүй юм байна лээ. Одоо бол Еврази дээр бид 50 гэдэг орон зайг авч байгаа. 50 хувь нь гадна талаас байж болно гэж. Тийм учраас бид дотооддоо шингээж байгаа нэмүү өртөг нь 50 хувьд нь багтаж чадвал манай бараа бүтээгдэхүүн аль болохоор өндөр технологитой газрын технологитой манай хөрөнгө оруулагч буюу манай ажилчидтайгаар гарвал энэ зах зээл рүү бараагаа гаргаж чадна.

Бидний хүсэж байгаа зүйл ноосон эдлэлээ 4, 500 сая долларт хүргэе гэж ноос ноолуур. Махныхаа экспортыг 4, 500 сая долларт хүргэе гэсэн ийм л маш энгийн зорилт байгаа. Тийм учраас их хумигдмал орчны гэрээ явж байна, явж байгаа 375 бүтээгдэхүүн явж байгаад 8 хасагдаад 367 бүтээгдэхүүн дээр асуудал яригдаж байгаа шүү гэдгийг.

Л.Соронзонболд: Цогтгэрэл гишүүн нэмэлт 1 минут.

О.Цогтгэрэл: Гантөмөр даргаас нэг гүйцээгээд хариулаад өгөхийг хүсье. Аливаа ажил дээр тэр тусмаа эдийн засгийн ажил чинь тоогоор илэрхийлэгддэг. Энэ дээр бодит үр дүн яаж гарах вэ? Одоо бид нарт 96-г харьцах нь 4, 100 хувь гээд үзвэл ийм харьцаатай гадаад худалдаа хөрш оронтойгоо евразитайгаа хийж байгаа. Энэ хэлэлцээрийн үр дүнд 3 жилийн дараа энэ 96-г харьцах нь 4 гэдэг харьцаа хэрхэн яаж өөрчлөгдөх вэ 1 дүгээрт? Энэ Хөдөө аж ахуйн яамны төлөөлөл байгаа байх гэж бодож байна. ХААЯ-ны төлөөлөл энэ хэлэлцээр хийгдээд, гадагшаа мах гаргах л гол зорилго тавиад байгаа. Энэ үнийн асуудлаасаа гадна тэр хорио цээр, стандарт, гарал үүслийн асуудал дээр бид нарт энэ татварын хөнгөлөлт авсан ч гэсэн энэ саяын тэр шаардлагууд дээр бид манай Монгол Улсын мах махан бүтээгдэхүүн боломжтой байгаа юу, тэр нөгөө халдварт өвчин, хорио цээр, олон

зүйлүүд дээрээ бид ямар нөхцөлтэй байгаа юм бэ? Ийм хөнгөлөлт гарангуут бид ашиглахад бэлэн байгаа юу? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Л.Соронзонболд: Хэн хариулах вэ? Эхлээд Гантөмөр сайд эхний нөгөө нэг тоон дээр хариулах уу? Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Үгүй ээ яах вэ манай Цогтгэрэл дарга бизнес хийгээд үзчихсэн хүн шүү дээ. Анх хэдэн төгрөгөөр үйлдвэрлэл эрхэлж байлаа, өнөөдөр хэдийн бараа зарж болж байна. Яг энэ шиг тухайн компаниудаас шалтгаална шүү дээ бодит байдал дээр. Би Говь компанийн өмнөөс ноолуурыг үйлдвэрлэж чадахгүй, манай ЗГ Говь компанийн өмнөөс тэр бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг тодорхойлоход бэрхтэй. Бид ЗГ бүх түвшинд дэмжинэ. Манай ноолуур, ноос үйлдвэрлэгч маань өрсөлдөнө. Махан дээр ч гэсэн бид аль болохоор уян хатан нөхцөлүүдийг олж авна. 40 хувийн татварыг нь тэглэж байгаа. Дээр нь гарал үүсэл дээр нь хөнгөлөлтийг авч байгаа, бараа бүтээгдэхүүн нь хурдтайгаар нэвтэрдэг болгож байгаа. Зүгээр тэр зах зээл дээр хэр амжилттай байх вэ гэдэг та надаас асуултгүйгээр мэдэж байгаа.

Л.Соронзонболд: Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Болорчулуун дарга 5 номерын микрофон нээе.

Ц.Болорчулуун: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Цогтгэрэл гишүүний асуултад хариулт өгье. Тэгэхээр ер нь махны экспортоор бид 17 оронтой хорио цээрийн протоколд тохирсон байгаа. Тодорхой хэмжээнд тохирсон хүрээндээ махны экспорт явж байгаа. Гоц халдварт гадаад хорио цээртэй 4 төрлийн өвчин байгаа: Тэгээд энэ 4 төрлийн өвчин сүүлийн 3 жил тайван гэдэг нөхцөл байдалтай байгаа. Тэгэхдээ яг эрүүл гэсэн баталгаажуулалтаа Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас аваагүй. Сүүлийн 2 жил гоц халдварт өвчнөөр тайван байж байж 3 дахь жилдээ энэ эрүүлийг баталгаажуулах энэ хүсэлтээ гаргадаг. Хүсэлтээ гаргаад ДЭМБ-д шүлхий өвчнөөр тайван гэдэг хүсэлтээ гаргаад явж байгаа. Мэдээж экспортлох, экспортлогч, импортлогч орны тавьдаг гол шаардлага тухайн улсын бүтээгдэхүүнд ялангуяа.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гүйцээж хариулъя 5 номерын микрофон.

Ц.Болорчулуун: Тэгэхээр энэ хорио цээрийнхээ протоколоор тохироод явсан нөхцөлд махны экспорт явах бүрэн бололцоотой гэж үзэж байгаа.

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Эрхэм гишүүдээ нэг ийм зүйл байгаа юм. Монгол Улс өнөөдрийн байдлаар 11 аравны, өнгөрсөн жил 11 аравны хэдэн тэрбум долларын бараа импортолсон. Энэний 3 тэрбум нь шатах тослох материал байгаа, 1 тэрбум гаруй нь машин байгаа, 1 тэрбум орчим нь тоног төхөөрөмж байгаа. Ингээд өргөн хэрэглээний бараа 7 тэрбум долларын импорт хийдэг юм, 7 тэрбум. Энэ 7 тэрбум доллар цаашаага асар ихээр нэмэгдэх ийм бололцоо байхгүй. Яагаад гэвэл бид экспортоос олж байгаа валютынхаа хэмжээнд л импортоо хийнэ. Энэ бол Цогтгэрэл даргаа тийм далай шиг цутгачихдаг зүйл ерөөсөө биш. Байгаа хэрэглээндээ л бараагаа авдаг. Тийм учраас энэ 7 тэрбум долларын бараа хаана оршиж байна вэ гэхлээр барилгын салбар дээр харагдаж байгаа цонх болоод бусад эдлэл болж харагддаг. Дэлгүүрүүд дээр хүнс болж харагддаг.

Л.Соронзонболд: Асуулт асуух гишүүдийн нэрс дээр Батболд гишүүний нэрийг нэмье, Шижир гишүүний дараа. Алдаржавхлан гишүүний микрофоныг нээе.

Ж.Алдаржавхлан: Энэ хэлэлцээрийг эдийн засгийн том хэлэлцээрийг зарчмын хувьд дэмжихээс аргагүй байгаа. Гэхдээ хэд хэдэн санаа зовниж байгаа юмыг хэлэхээс аргагүй байна. Эрчим хүч, Эдийн засгийн сайдаас асуухад ер нь энэ хэлэлцээрт орсноор манай төсвийн нөгөө орлого чинь буурах уу, гаалийн болон бусад татварууд маань буурах юм уу, үгүй юм уу? Энийг тоон үзүүлэлтээр хэлж өгөөч. Бид нэг эдийн засгийн энэ евразийн түр хэлэлцээр хийж байгаа юм. Энд 3 жилийн, 3 жилийн хугацаанд орох юм байна. Экспортоо дэмжье гээд байгаа. Тэгээд энэ 3 жилд чинь нөгөө экспортод чиглэсэн үйлдвэрүүд чинь баригдаж амжих юм уу? Тийшээ экспортод гаргах чиглэлээр олон үйлдвэрлэлүүд байгуулагдаад, экспортод гаргах тийм бололцоо үүсэх юм болов уу 2 дугаарт?

3-т 3 жилийн дараа эргээд харсан чинь хэдэн үндэсний үйлдвэрлэл чинь сөхрөөд уначихсан байх юм биш байгаа? Та хэд судалгаа шинжилгээ хийж үзсэн үү? Энийг нэг хариулж өгөөч гэж байгаа юм. Сая Цогтгэрэл сайд яриад байна шүү дээ. Гурилын импортын татварыг байхгүй болгочихсон чинь манай үндэсний үйлдвэр 40 хувиар буусан гэж байгаа юм. Хамгийн энгийн жишээ л хэдүүлээ авч үзье. Орост үйлдвэрлэсэн цэвэр ус хамаагүй хямд үнэтэй байгаа. Монголд орж ирэхэд иргэн алийг нь авах вэ? Үнэтэй Монголынхыг нь авах уу, арай хямд байгаа Оросын цэвэр усыг авах уу? Цэвэр ус чинь тэг гэж байгаа шүү дээ тариф нь тэг гэж байгаа байхгүй юу. Виски энэ тэр гээд бүгдээрээ л тэг юм байна лээ. Ерөөсөө бүхий л зүйлд тариф байхгүй. Тэгэхлээр иргэн алийг нь сонгох бол? Энэ тал дээр та хэд ерөнхийдөө тооцоо хийж үзсэн юм болов уу? Ер нь тэгээд л манай нөгөө экспортын үйлдвэрүүд 3 жилийн хугацаанд баригдаж амжихгүй бол гадагшаа гардаг валют маань нэмэгдэх юм биш байгаа гэсэн ийм болгоомжлол байгаа. Гэхдээ зүгээр энэ болгоомжлол шүү таавар бол биш. Тэгэхлээр та Эдийн засгийн сайдын хувьд хариулж өгөөч гэж хүсэж байна. Тэгээд ер нь энэ хэлэлцээр том агуулгаараа дэмжиж байгаа гэдгийг хэлчихье.

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Тэгэхээр ер нь бид энэ үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах үзэл санаанаасаа ер хэрхэвч ухарч болохгүй. Алдаржавхлан гишүүний энэ саналтай санал нэг байгаа. Бидэнд байгаа хэрэгслүүд бий. Жишээлбэл төсвийн мөнгөөр төсөв маань их том орон зайтай болчихсон. Төсвийн мөнгөөр бид өргөн хэрэглээний барааг авахдаа зөвхөн дотоодын бүтээгдэхүүн авна гэж хэдүүлээ хуульчилмаар юм байна лээ. Ерөөсөө энэ хүнээс айж ичихгүйгээр зүгээр үндэсний үйлдвэрлэлээ худалдаж авна 1 дүгээрт.

2 дугаарт үндэсний энэ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийхээ НӨАТ-ын буцаалтыг хэдүүлээ өндөр түвшинд хүргэж болох юм байна лээ. Жишээлбэл Монгол улс худалдаж авбал НӨАТ-ын буцаалт чинь 5 хувь байдаг, 6 хувь байдаг. Гаднын улсыг худалдаж авбал НӨАТ-ын буцаалт нь 1 хувь байдаг эсвэл zero байдаг ийм байдлаар хэдүүлээ үндэсний үйлдвэрлэлээ бүрэн хамгаалах боломж бололцоо байгаа 1.

2 дугаарт ер нь энэ Еврази маань өөрөө хөөрхий Солонгостой, Японтой, Хятадтай өрсөлдөөд Монголын зах зээл дээр бараагаа зарна гэдэг маш хүнд л юм байна лээ бодит байдал дээр. Бодит байдал шүү энэ бол. Тийм учраас манайх

юугаараа онцлогтой вэ гэхлээр гаалийн тариф их багатай учраас зах зээл асар нээлттэй улс байхгүй юу. Бидний нэг давуу тал байна. Тэгэхээр та бүхэн дэлгүүр ороод харвал бяслаг Еврази өрсөлдөнө л гээд байгаа юм. Тэгэхдээ бяслагийн ихэнх нь Европын холбоо байгаа. Йогурт дээр өрсөлдөнө л гээд байгаа юм. Йогурт нь ихэнх нь Солонгос, Хятад йогурт байгаад байгаа гэх мэтчилэн. Усан дээр өрсөлдөнө гээд тэгэхэд ус нь ялгаа байхгүй Хятад, Хятад биш ээ, Солонгос ус дэлгүүрээр дүүрэн байгаад байгаа. Бид яг хэлэлцээрийн явцад дэлгүүрийн лангууг очиж үзэж байгаа юм л даа. Тэгээд тэр дэлгүүрийн лангуу айхтар солигдохоор дүр зураг ерөөсөө харагдахгүй. Хамгийн гол нь бид Евразийн лангуун дээр өөрийнх нь made in mongolia гэсэн барааг л тавимаар байгаа юм гэдэг рүү л хэдүүлээ явж байгаа юм 1.

2 дугаарт гишүүнээ 3 жил болоод шууд дуусах юм биш. 3 жил болоод аль нэг тал нь горимын саналгүй бол 3 жилээр автоматаар сунах юм. Жишээлбэл 3 жилийн дараа Еврази тал энэ асуудал байна гэвэл зогсоно. Бид асуудал байна гэвэл зогсоно. Асуудал алга аль, аль нь яг л төлөвлөгөөнийхөө дагуу явж байгаа гэвэл 3 жил автоматаар сунана. Ингээд харилцан нэгнийхээ бүтээгдэхүүнд тодорхой хэмжээнд дасаад, хэрэглээд, харилцаанд ороод сурчихсаны дараа энэ сунахад бэлэн ийм хэлэлцээр байгаа гэдгийг хэлмээр байна. Төсвийн орлого буурна шүү дээ. Гаалийн татвартай холбоотой 300 тэрбум орчим төгрөгийн татвар ирэх жилээс хасагдана. Тэгэхдээ өнөөдөр бид нөгөө бэлэн худалдаж авч байгаа бараан дээрээ шүү. Тэгэхдээ өнөөдөр жишээлбэл бид ОХУ руу бараа худалдаж аваад төлбөрөө шилжүүлэх бололцоогүй байгаа. Тэгэхээр одоо юу юугүй гэрээ хийгдлээ гээд тэндээс бараа Монгол руу асгарахгүй. Яагаад гэвэл бид төлбөр шилжүүлэх бололцоогүй байгаа. Тэр талаас төлбөр шилжигдэж байгаа. Бид бараагаа зарлаа гэвэл нөгөө тал маань Монгол руу төлбөр шилжүүлж байгаа. Тийм учраас айхтар ингээд бараа асгараад, татвар багасаад, орлого буураад гэдэг зүйл гарахгүй гэж харж байгаа.

Л.Соронзонболд: Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Сүүлийн үед ОХУ-тай хийж байгаа энэ гэрээ хэлэлцээрүүд их тийм эмзэг болчихоод байгаа юм. ОХУ-ын манай нэг том хөрш улс байгаа. Тэгээд эсэргүүцэх чиг хандлага нэлээн тийм давамгайлаад байгаа. Түлшний асуудал дээр гарцаа байхгүй бид бодох ёстой асуудал байсан. Энэ Евразийн хэлэлцээр дээр зүгээр ОХУ-тай бид хэлэлцээр хийхэд эргээд 3 жилийн дараа Япон шиг л болчихгүй бол алдах юм үгүй байх гэж би бодож байгаа юм. Гэхдээ манай Эдийн засгийн сайд саяын бид нарын ярьсан энэ олон асуудал дээр нэг тооцоо судалгаа хийгээд, хэрвээ асуудал жаахан хүндрээд ирвэл жилийн дараа энэ тэр энэ хэлэлцээрээсээ энэ тэр гарч болох уу, тийм бололцоо байхгүй юу? Тэрийг албан ёсоор яг микрофон дээр хариулаад өгчих. Байдал хүндрээд бидний бодсон шиг биш боллоо гэж бодъё, нөгөө айхтар ... чинь далай шиг урсаж орж ирээд манай үндэсний үйлдвэрлэл хэвтээд эхэлбэл та жилийн дараа энэ хэлэлцээрээс гарч чадах уу? Албан ёсоор хариулчих.

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Ер нь төрийн бодлого, аливаа бодлого гарахдаа 7 хэмжиж 1 огтолдог л доо. Тэгээд энэ бодлого ингээд анх удаагаа энэ парламент руу орж ирээд, энэ парламент, энэ ЗГ шүүрч аваад хийж байгаа зүйл ерөөсөө биш шүү гишүүдээ. Та бүхэн өмнөх, өмнөх парламентууддаа итгээрэй. Өмнөх, өмнөх Засгийн

газрууддаа итгэх хэрэгтэй. Тэр 2050 гээд урт хугацааны хөгжлийн хөтөлбөр дотор яг үг үсгээрээ байдаг зүйл. Яагаад би оруулсан байдаг тухай тайлбарлах гээд байгаа вэ гэхлээр энэ чинь ингээд Монгол Улс хөгжихийн тулд энэ зах зээлтэй заавал гэрээ хийх юм байна гэдгийг бүх түвшинд эрдэмтэд нотолдог зүйл байхгүй юу. Тэгэхдээ өөрийнхөө дотоодын үндэсний үйлдвэрлэлээ хамгаал гэдэг ийм параллель өгөгдөлтэй. Тийм учраас бид нэг жилийн хугацаатай ч гэдэг юм уу, нэг гэрээ хийчхээд дундаас нь хаядаг ийм зүйл байхгүй. Бид тууштай, Монгол төрийн бодлого их тогтвортой байгаасай гэдэг үүрэг даалгавар аваад, би энийг өргөн барьж байгаа юм. Түүнээс биш.../минут дуусав/

Л.Соронзонболд: Батбаярын Жаргалан гишүүний микрофоныг нээе.

Б.Жаргалан: Бид угаасаа зах зээлээ тэлж байж уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж байж л эдийн засгаа өсгөнө, тэлнэ, иргэдийн хаалгаар айл өрхийн хаалгаар эдийн засгийн өсөлтийг оруулна гэж зөндөө ярьдаг. Тийм ч бодлого хэрэгжүүлэх ёстой гэж боддог. Гэхдээ нөгөө талаасаа зах зээлээ тэлнэ гээд энэ чөлөөт худалдааны хэлэлцээр бол зах зээлээ тэлэх зорилготой гэж яриад байгаа. Тэгээд Японыг л янз бүрээр яриад байна л даа. Тэгээд би сая 1 зүйлийг гайхлаа. Японтой хэлэлцээр үнэхээр ингээд ийм асуудалтай байгаа, тэгээд дүгнэлтүүд нь үнэхээр гарсан эсэх энэ тэр дээр хариулт өгсөнгүй яамнаас. Гэхдээ ядаж нэг байгуулчихсан хэлэлцээрийнхээ нөхцөлийг нь сайжруулах тал дээр ажилладаггүй юм уу, тийшээгээ бараа бүтээгдэхүүн гарах талаар ямар нэгэн эрмэлзэл хичээл зүтгэл гаргадаггүй юм уу? Тэр тал дээр яам нэг хариулж өгөөч, ямар дүгнэлт гарав? Манай худалдааны тэнцэл цаашид ямар байдлаар сайжрах боломжтой вэ? Бид ер нь энэ асуудлыг сайжруулахын тулд юу хийж байгаа вэ? Яагаад гэхлээр нэг байгуулчихсан юмаа бид дахиад янзлах ёстой шүү дээ.

Тэгээд энэ Евразийн эдийн засгийн холбоотой хэлэлцээр байгуулсан бусад харьцангуй ОХУ-тай харьцуулбал жижиг улс орнууд байгаа. Тэдгээрийн нэг туршлага дээр ямар анализ хийв? Өндөг жишээлбэл 90 сая гээд л яриад байна. Гэтэл манайх дотоодын бүтээгдэхүүн, дотоодын үйлдвэрүүд хүчин чадлаа нэмээд 30 сая ширхгийн дутагдалтай гэсэн мэдээлэл авсан байгаа. Би өнгөрсөн хугацаанд ер нь үндэсний үйлдвэрлэгчид, импортлогчид төрөл бүрийн л хүмүүстэй ярилаа. Тэгээд янз бүрийн л зүйлүүд ярьж байна. Манайх мах нийлүүлнэ л гэж яриад байгаа гэтэл тэр хорио цээр энэ тэрээс гадна ер нь бид нарт тийм махны тэр тээвэр логиستيкийн боломж, бололцоо нь их хомс байгаад байна шүү дээ. 150 мянган тонн мах гэдэг чинь маш их хэмжээний мах шүү дээ. Ноолуурын салбарынхан төдийлөн энэ зах зээлийг сонирхохгүй байна. Яагаад вэ гэхлээр илүү өндөр орлоготой зах зээлүүд рүү бэлэн бүтээгдэхүүнээ явуулахыг зорьж байна. Итали руу утас энэ тэр гаргаж байна ч гэдэг юм уу.

Магадгүй уламжлалт зах зээлээ бодвол нөгөө хивс энэ тэр гэсэн чинь Турктэй өрсөлдөхөд хүнд байна гэсэн зовлон ярьж байна. Нөгөө савхин бээлий энэ тэр гээд бүүр нөгөө уламжлалт 80, 90-ээд оны зах зээлүүд рүүгээ яаж хандаж байгаа юм гэх мэтчилэн яг ийм зах зээл болгон дээр бид нарт яг тодорхой судалгаанууд хэн, хэн ямар бүтээгдэхүүн гаргах вэ гэдэг зүйл ер нь байна уу? Тэгж байж бид ийм бодитой шийдвэр гаргах гээд байгаа. Тэгээд ОХУ-ын хувьд энэ хүнсний үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг, уламжлал ёсоороо ингээд үйлдвэрлэл их нэлээн хөгжчихсөн ийм зах зээл. Тэгээд манайх ч гэсэндээ 90-ээд онд.../минут дуусав/

Л.Соронзонболд: Жаргалан гишүүнд нэмэлт 1 минут.

Б.Жаргалан: Манайх жишээлбэл 90-ээд онд бүгдээрээ хөдөө хотгүй шар савлагаатай тетрапак сүү уудаг байсан, моя семья, любовь моя гээд жүүсний реклам манай бүх телевизээр явдаг байсан. Манай энэ 7 тэрбумын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний бүтэц чинь Солонгосоос авдаг ийм Орос руу Оросын бүтээгдэхүүнээр солигдох гэх мэтчилэн зөвхөн үндэсний үйлдвэрлэгч биш худалдаачдын барааны бүтцэд өөрчлөлт орох магадлалтай байна. Энэ талаар судалгаа хийгдсэн үү? Тэгээд эцэст нь энэ төлбөр тооцоогоо яаж хийх юм бэ? Саяхан л жишээлбэл бензинийхээ мөнгийг төлж чадахгүй байна гэсэн шилжүүлж чадахгүй байна гэсэн асуудал үүсээд байсан. Тэгээд тэндээс бид жишээлбэл бараа зарлаа гэж бодъё аягүй сайнаар бодоод мөнгөө яаж шилжүүлж авах юм гэх мэтчилэн маш олон асуултууд байгаад байгаа юм. Тэгээд санхүүгийн холбоотой бэрхшээлүүд гарах уу гэх мэтчилэн. Энэ нөгөө нэг танилцуулга дээр байхгүй байгаад байгаа зүйлийг л би асуухыг зориод байна л даа. Яагаад гэхлээр бид их урт хугацааны шийдвэр гаргаж байгаа байхгүй юу.

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Ер нь бид Жаргалан гишүүний хэлж байгаагаас анзаарахад энэ гадаад харилцаагаа бид эдийн засагжуулмаар юм билээ. Жишээлбэл Японы худалдааг идэвхжүүлж чадахгүй бол тэр Японы Элчин сайдыг жилд нь татдаг байх хэрэгтэй. Тэр Осакагийн Консул гэдэг нөхөр юу хийж байдаг юм, тоглоом биш шүү дээ. Ерөөсөө Японд байгаа Элчин сайд ажил хийдэггүй, энэ Гадаад яам ажил хийдэггүй учраас тэр зах зээл дээр бид нэвтэрч чадахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр нэг бол Монголын барааг зардаг байна, эсвэл тэрийг татан буулга гэдэг ийм шаардлагыг тавина. Европын холбоо ч адилхан. Европын холбоонд их л айхтар дипломат харилцаа хийгээд байдаг. Хэдэн дарга нар очихоор үйлчлэхээс өөр ажил байдаггүй. Тэр нөхдүүдийг буцаах хэрэгтэй. Эсвэл Монголын барааг тэр зах зээл рүү оруулах ажлыг хий гэж үүрэг өгөх хэрэгтэй. Би бол ОХУ-д суугаа Элчин сайдад ийм л үүрэг өгнө. Гэрээ хийсэн. Энэ хэмжээнд хийхдээ бодож байсан хэмжээний барааг энэ зах зээл дээр зарах ажлыг та хийнэ. Хийж чадахгүй бол ажлаа өг гэдэг ийм л асуудал ярина. Тийм учраас бид энэ гадаад харилцаагаа жоохон эдийн засагжуулаад, эдийн засгийн өгөөжтөйд нь хүнээ суулгаад, огт эдийн засгийн өгөөжгүй, харилцаанд ордоггүй байгаа тэр хэсгийг татаж буцааж Монголд авчрах, магадгүй ирэх оны төсөв ярих үед энэ гадаад харилцааны зардлыг ер нь 20-оос 30 хувиар бууруулах шаардлага байгаа байх. Энэ бол бүх түвшинд яригдах байх гэж би харж байгаа, 1 дүгээрт ийм зүйл байна.

2 дугаарт судалгаа хийсэн үү л гээд байна. Манайхан судалж, судалж байгаад л бидний зарж чадах бараа гээд тэр 375 барааг гаргасан юм байна лээ Жаргалан гишүүнээ. Бидний чадах бараа энэ юм гэж. Тэгэхээр бидний чадах бараан дээр нөгөө талд нөгөө айл ч гэсэн чадах бараагаа бүгдээрээ эрэмбэлж байгаа. Жишээлбэл Беларус бол сүү зарахыг хүсэж байгаа. Казахстан түрүүн хэлсэн тэр тамхи энэ тэрээ зарахыг хүсэж байгаа. ОХУ улс түлш, тослох материал зарахыг хүсэж байгаа гэх мэтчилэн ийм аль, аль нь өөрийнхөө чаддаг зүйлийг танай зах зээл рүү нэвтрүүлж гэдэг ийм л хэлэлцээр шүү дээ. Японы тухайд бид энэ Монгол Улс дотроо үнэхээр Япон руу хийж байгаа экспортолж байгаа компаниудаа тусад нь бойжуулах тэр системийг угсрахгүйгээр Японы зах зээл дээр өрсөлдөхөд их хэцүү.

2 дугаарт үнэхээр тэр гэрээ хэлэлцээр лүү бид дахиж нэвтрэх шаардлага бол байна. Нэвтрэхдээ аль байдлаар нэвтрэх вэ гэвэл бид энэ гарал үүсэл гэдэг зүйл

дээрээ тодорхой хөнгөлөлт авч байж тэгж байж Японы зах зээл рүү гаднын хөрөнгө оруулагчдын туслалцаатайгаар, гаднын үйлдвэрүүдийн оролцоотойгоор тэгж байж Японы зах зээл рүү гарна. Энийг Японы талд би бол ил шулуухан хэлж байгаа. Тийм учраас энэ ажил хийгдэнэ. Гол нь гадна талдаа нэг жоохон улсынхаа төлөө энэ нөхдүүд ажилламаар байна. Дипломат нэртэй ингээд зүгээр суугаад байдаг. Өнөөдөр жишээлбэл Евразитай хийж байгаа энэ хэлэлцээрийн ар дээр энэ 5 улсад суугаа Элчин сайдын яамнууд бүрэн бүрэлдэхүүнээрээ Монголын барааг тэнд сурталчлах ажил руу шууд орох хэрэгтэй.

Л.Соронзонболд: Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Бид аливаа чөлөөт худалдааны хэлэлцээрээс давуу талтай гарах эсэх нь харин бид нараас хамаарна гэдэгтэй санал нэг байгаа. Гэхдээ бид өнгөрсөн хугацаанд хувийн хэвшлээ үндэсний үйлдвэрлэгч нараа үндсэндээ нугасалчихсан байна шүү дээ. Татвараар, элдэв дарамт шахалтаар, элдэв янзын зөвшөөрлөөр. Тэгээд манай ер нь тийм үндэсний үйлдвэрлэгчид дунд өрсөлдөх чадвартай хүмүүс алга. Тэгээд энэ чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк, татварын хөнгөлөлт зэрэг иймэрхүү давуу талуудаа бий болгосны ар дээр иймэрхүү хэлэлцээрүүдээ эхлүүлсэн нь зөвгүй юу? Энэ чинь бас нэг цаг хугацааны наана, цааны асуудлууд байгаад байгаа юм биш үү? Яагаад гэхлээр үнэхээр манай үндэсний үйлдвэрлэгчид энэ ялангуяа энэ Евразийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай эсэх дээр маш их эргэлзэж байна. Яагаад гэхлээр бидэнд тэр логистик нь алга, тэвтрээ бид хийж чадах уу, үгүй юу? Худалдаа чинь маш олон хүчин зүйлтэй ийм салбар шүү дээ. Тэгэхээр бид өнгөрсөн хугацаанд ийм боломж бололцоо энэ ноу хауг дотооддоо бүрдүүлж чадаагүй.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Ер нь Монголын эдийн засаг нэг тийм монопол маягтай, олигопол шинжтэй байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Шинээр компаниуд төрөх, start-up-ууд гарч ирэх, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэрийг дотоодын зах зээлд эргэлтэд оруулах бололцоо үнэхээр байхгүй. Тийм учраас бид гадаад зах зээл нэмж нээж байж энэ start-up-уудын бойжилт бодитой бий болно шүү гэдгийг хэлмээр байна. Өнөөдөр энэ хэлэлцээрийг хойшлууллаа гэхэд 30 он хүртэл урт хугацааны зорилт Их Хурал баталчихсан шүү дээ, та бүхэн гишүүд минь нэг юмыг л хатуу баримаар байна. Их Хурлаар батлагдсан баримт бичгийг гүйцэтгэх, хийх нь ЗГ болоод та бидний үүрэг шүү дээ. Тэрийгээ л эргэж буцаад байвал бид амьдарч чадахгүй шүү дээ. Тийм учраас 2030 он хүртэл дахиад бид энэ хэлэлцээр хийх, өнөөдөр энэ хэлэлцээрийг хойшлууллаа гэвэл тэр том зорилтод байгаа бидэнд үүрэг болгоод өгчихсөн 2030 он хүртэл энэ хэлэлцээр хийх зорилт бол.../минут дуусав/

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Яах вэ зүгээр энэ хариултуудад явж байхад албаны хүмүүс ингэж байна л даа одоо л дэлгэрэнгүй ярихгүй болохгүй гээд. Одоо биш уг нь өмнө нь дэлгэрэнгүй ярьж, ойлгуулж, энэний ач холбогдол, энд нэгдсэний сөрөг болон давуу тал, давуу талыг бид олж авахын тулд ямар бэлтгэлтэй байх ёстойг хувийн хэвшилдээ уг нь таниулж байх ёстой байсан. Хувийн хэвшилдээ бэлтгэл хангах хугацааг нь өгч байх ёстой байсан. Гэтэл өнөөдөр хувийн хэвшил чинь эсэргүүцээд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр танхим нэг байр сууриа хэлчих

нь зөв байх. Тэгэхээр одоо дэлгэрэнгүйгээр нь биш, аливаа шийдвэрүүдийг боловсруулж оруулж ирэхээсээ өмнө дэлгэрэнгүй ярьж нуудаг биш, хэн нэг дарга нарын хоорондын ярьсан зүйлийг болчихсон мэтээр ингээд ярьдаг байдал руугаа хэдүүлээ болимоор байгаа юм.

Яг үнэндээ хэлэхэд энийг нэг их дэлгэрэнгүй ингээд олон нийтэд хэлэлцүүлээд ийм нөхцөл байдал байна шүү, шинэ зах зээл рүү бид хэд орох хэрэгцээ байна эд нар гэдгийг таниулж байсан би хэлэлцүүлэг уулзалтуудыг ер нь тун цөөхөн санаж байна. Ерөөсөө л энэ бид нарын алдаа, хандлагын алдаа. Тэгээд өнөөдөр яах вэ гишүүдийг буруутгаад ч юм уу ингээд байх биш, гишүүд чинь болгоомжлоод байгаа байхгүй юу. Яагаад гэхээр адилхан олон нийттэйгээ адилхан мэдээлэлгүй байна. Тэгээд эдийн засаг ийм амаргүй, эргээд энэ дэд бүтцийн хомсдол, хүртээмж байхгүй энэ үе дээр манай ААН, байгууллагууд том зах зээл рүү хэр орох бэлтгэлтэй байдаг юм доо? Энэ дээр яг албаны байр суурийг хэлээч? Хэчнээн аж ахуйн нэгж, байгууллага, хэчнээн нэгж төрлийг ер нь оруулах бэлтгэлийг ер нь хангаж байгаа юм бэ? Тэр 360-аад гэдгийг ерөнхий багцаагаар хэлж болно. Тэгэхдээ яг бодит яг энэ зах зээлийг нээчихвэл давуу байдлыг олж авах хэчнээн ААН байгаа юм бэ?

Би яах вэ зүгээр Эдийн засгийн хөгжлийн яамны сайд байгаа дээр жоохон болгоомжтой яримаар байна. Өнөөдөр эдийн засгийн нөхцөл байдал зах зээлийн багтаамжаасаа шалтгаалаад монопол талдаа ч юм уу байж магадгүй байх. Энийг бид зөв болгох нь зөв. Тэгэхдээ өнөөдөр бизнес хийж байгаа ААН байгууллагуудаа та нар бол критель хуйвалдагч нар, ийм залхуу гэж хэлж болохгүй. Энэ бол тун болгоомжгүй үг. Өнөөдөр Эдийн засгийн хөгжлийн зөвлөл дээрээ та нар зэрэгцээд сууж байдаг юм байна лээ шүү дээ. Та яг энэ үгээ өөдөөс нь харж байгаад хэлэх ёстой байхгүй юу. Одоо залхуурмааргүй байна. Тэгэхдээ эргээд нэг зүйл байна. Энэ хэлэлцээрт ороод бид хичээх ёстой гээд. Бид гэдэг зүйлийг 2 хувааж үзэх ёстой. 1 дүгээрт бид гэдэгт төр байх ёстой, бид гэдэгт хувийн хэвшил байх ёстой. Хувийн хэвшил яах вэ бэлэн оролдоод үзэх боломж байхад төр харин бэлэн байна уу? Бид боловсон хүчний хомсдолыг нь шийдэж өгч чадаж байна уу? Дэд бүтцийн хүртээмжийг нь, цахилгаан, дулааныг нь татаж өгч чадаж байна уу? Энэ бүх зүйлүүдээсээ бодоход магадгүй энэ 3 жилийн түр хэлэлцээр чинь 30 жилийн гамшиг болох вий дээ гэдэг л болгоомжлолыг зүгээр яриад байгаа байхгүй юу.

Дээрээс нь 2009 онд ЗГ-ын ганц шийдвэр байдаг шүү дээ. Малын түүхий эдийг л экспортыг зогсоох, баригдаагүй аж үйлдвэрийн паркт зориулж. Тэгээд өнөөдөр малчдыгаа ядуу сэтгэлгээнд байлгах хамгийн том бодлого тэндээс л эхэлж байсан.

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүнд 1 минут. Худалдаа, аж үйлдвэрийн танхим 9 номер микрофон нээе.

Л.Төр-Од: Сайн байна уу. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Танхимаас ерөнхийдөө зарчмын хувьд дэмжиж байгаа. 3 удаагийн томоохон хэлэлцүүлгүүд хийсэн. 23 онд 1 хэлэлцүүлэг 12 дугаар сард, 24 онд 5 сард 1 хэлэлцүүлэг, яг энэ Евразийн эдийн засгийн хэлэлцээрийн түр хэлэлцээрийн төслийн талаар 12 дугаар сард томоохон хэлэлцүүлгүүд хийсэн байгаа. Тэгээд түрүүн яах вэ манай нөгөө Ганбаатар гишүүн дурдаж ярья. Энд бид зөвхөн нөгөө топ 100-аас илүүтэй дунд, жижиг бизнес эрхлэгч, экспортлогчдыг илүүтэй оролцуулсан байгаа. Мөн танхимын болон танхимын бус гишүүдийг. Яагаад гэвэл эргээд нөгөө танхимын статистикийг харахаар бараг 70-аас дээш экспортлогч маань

тун жижиг бизнес эрхлэгчид байгаа. Тийм учраас ерөнхийдөө хувийн хэвшлийн мэдээж хэрэг бид нөгөө нийт төлөөлж байгаа учраас том болон жижиг, дунд, зарим гарааны бизнес эрхлэгчид ч гэсэн цахим худалдаа e-commerce-р экспортлоод эхэлчихсэн байна. Тэрийг нь бид Европын холбооны төсөл, эргээд хөрөнгө оруулалт, худалдааны агентлагтай ингээд хамтраад хийж байгаа.

Гол эргээд хэлэх нэг л статистик байгаа. Бид урд хөршөөсөө бараг 90 гаруй хувь нь экспортод явж байгаа. Евразийн эдийн засгийн холбооны 5 оронтой 0,7 хувь ч хүрэхгүй байгаа шүү дээ. Энэ дээр та минь, та хэд маань ингэж анхаарч үзээрэй. Өөрөөр хэлбэл бид эдийн засгаа экспортоо төрөлжүүлбэл, эргээд манай экспортлогчдод гол тулгарч байгаа асуудал худалдааны санхүүжилт болон төслийн санхүүжилт байгаа. Тийм учраас бид сая Хөгжлийн банктэй хэлэлцүүлэг хийгээд, Хөгжлийн банкны чиг үүргийг илүү ялангуяа уул уурхайн бус экспортыг дэмжих зорилтот санхүүжилт, 2 дугаарт бүрэн циклээр нь экспортод зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих бүрэн циклийн төслийн санхүүжилтийн шугамыг нээхээр хамтын ажиллагааны гэрээ байгуулаад ажиллаж байгаа. Баярлалаа.

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Ер нь яг ажил хийж байгаа хүмүүс дэмжиж байгаа. Би түрүүн тэр нөгөө монопол эдийн засагтай гэдэг нь манайх цэвэр уул уурхай руу хазайчихсан шүү гэдгийг хэлээд байгаа юм шүү. Тэгээд нөгөө зах зээл нь жоохон босоогүй учраас тэнд олигопол маягийн юм байна гэж хэлж байгаа шүү. Түүнээс би хувь компани руу ерөөсөө дайрсан юм байхгүй. Сайнзориг гишүүн тэрийг миний ойлголтын алдаа байвал засаарай та.

2 дугаарт их 30 жилийн гамшиг гээд. Би энэ Евразийн хэлэлцээрийн тухай гадуур айхтар, айхтар болгоомжлол, айхтар ухаалаг мэдэгдлүүдийг аягүй их харж байна. Тэгэхдээ жоохон тийм зүгээр би Ардчилсан намынхандаа жишээлбэл хэлж байгаа юм. АН жишээлбэл нэг хөршөө үгүйсгэдэг нам байж болохгүй шүү дээ. Тэгвэл энэ хөршийг дэмждэг нам гээд төрчихвөл бид яах юм бэ? Тэгээд тэрэнтэйгээ хэрүүл хийгээд суугаад байх юм уу.

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Би тодруулчихъя. Би яах вэ зүгээр ер нь аливаа зүйлийг би урд, хойд хөршийг нэг их уянгалаад л миний ах, урд хөршөө миний дайсан гэдэг энэ уянгалал зогсох үед жоохон бодитой нүдээ нээх байх. Ер нь зүгээр төрийн институт яг энэ нүдээр харах ёстой. Тэгээд энэ дээр таны тэр зарчмыг ойлгож байна. Тэгэхдээ таны үгэнд картель хуйвалдагч нар гэж хэлсэн шүү. Энэ дээрээ би Эдийн засгийн сайдын хувьд бизнес эрхлэгчдээ арай тэгж тодорхойлж болохгүй байх. Одоо дотоодын зах зээлээсээ гадагшаа гарах оролдлогыг хийгээч л гэдэг зүйлийг таны хэлж байгаа өнцгийг би дэмжиж байна.

2 дугаарт таны ам болгоноос том шийдвэрүүд дээрээ уг нь хэлээд байгаа юм. Тэгэхдээ бодит ажил оруулж ирмээр байгаа юм Гантөмөр сайдаа. Та Монгол Улсын паспортыг хүчирхэг болгож байгаа, эдийн засгийн буюу хөрөнгө оруулалт татаж байгаа байдлаар нь Элчин сайд юм уу, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн ажлын үзүүлэлтийг дүгнэдэг больё гэдэг энэ саналыг. Анх энэ саналыг би ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэж байхад хэлж байсан юм. Батцэцэг сайд хариулж

байсан санагдаж байна. Энийгээ ингээд ЗГ бодитой ажил болгоод оруулаад ир л дээ, хэдүүлээ ингээд.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Тийм, харин би түрүүн зүгээр аль нэг ААН рүү хэлээгүй гэдгээ дахиад нотлоод хэлчихмээр байна. Энэ картель монопол гээд байгаа чинь төрийн оролцоо асар өндөр байгаа тухай л бид яриад байгаа шүү дээ. Энийг задалж энэ уул уурхайн хамаарал, хэт хамаарлыг задлах ганц арга байна бидэнд, илүү олон юм алга. Бодит амьдрал дээр манай энэ 250 мянган малчин өрх байна. 450 мянган хүн тэнд ажиллаж, амьдарч байна. Энийг бид хөнгөн үйлдвэрээр дамжуулаад үнэ цэнтэй болгох арга бол өөрөө энэ эдийн засгийн монополийг арилгах боломж. Өөр бид өөртөө байгаа зүйлийг л бүтээж, бүтээгдэхүүн болгож, үнэ цэн бий болгож байж л энд шинэ эдийн засаг бий болох юм байна лээ. Тэгээд энэнээсээ зугтаагаад байвал яг энэ монопол зах зээл одоо ингээд л яг төрийн л юу байгаа биз дээ бүх юм чинь, бид харж байгаа шүү дээ. Тэгээд энэ байдал чинь ерөөсөө арилахгүй нь. Нөгөө солонгорох барих, урд, хойд хөршийн тэнцвэр хадгалагдах, нөгөө аюулгүйн.../минут дуусав/

Л.Гантөмөр: Цаг дууссан. Энхтүвшин гишүүн. Түрүүн нэмчихсэн шүү дээ, нэмэлт 1 минут өгье. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Гантөмөр сайдаа би уг нь таны хэлж байгаа юмнуудыг дэмжээд байгаа юм. Та яг сая нөгөө энэ элчин сайдын томилгоо байдаг юм уу, Элчин сайдын яамнуудын томилгоо дээр наад зарчмаа оруулаад ир л дээ 1 дүгээрт. 2 дугаарт магадгүй эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байдаг юм уу, гадаад худалдааны энэ хэлэлцээрүүдийг дагаж байгаа хийгдэж байгаа энэ цаг үед уг нь бид яг иж бүрнээр нь хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих, эргээд энэ дэд бүтцийн хөрөнгө оруулалтад төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж оруулж ирэх энэ багц хуулиуд чинь хамтдаа орж ирвэл итгэл үнэмшил суух гээд байна. Өнөөдөр бид хэд байна шүү дээ яг энийг ийм ганган, ганган хариултуудыг 8 сар сонсоод сууж байгаа байхгүй юу. Орж ирэхгүй байна шүү дээ. Тэгэхээр яг энэ хэлэлцээртэй зэрэгцээд оруулаад ирээч гэдэг зүйлийг л та нөхдөөсөө гуйгаад байгаа байхгүй юу. Хэзээ бэлэн болох юм бэ? Хэлэлцээр явчихлаа, тэр араас нь хувийн хэвшлээ дэмжих хуулиуд хэзээ орж ирэх юм бэ? Тэгээд хөрөнгө оруулалтуудыг татах хуулиуд хэзээ орж ирэх юм бэ? Бид хэд өөрсдөөсөө шалтгаалах юмаа хиймээр байна шүү дээ. Тэгэхээр өөрсдөөсөө гэдгийг нэг талдаа бид хэд төр гэж ойлгох хэрэгтэй. Өөрсдөөсөө гэдгийг хувийн хэвшил гэдэг, хувийн.../минут дуусав/

Л.Соронзонболд: Хэн хариулах вэ? Гантөмөр сайд хариулах уу? Хэзээ оруулж ирэх вэ гээд асуугаад байна.

Л.Гантөмөр: Ер нь бизнесийн орчныг сайжруулах төлөвлөгөөг бид заавал хэрэгжүүлнэ. Энэ бол нэг хуулиар шийдэгдэх асуудал биш гэдгийг Сайнзориг гишүүн хуульч хүний хувьд маш сайн мэдэж байгаа. Бүртгэлийн хуулиуд байна, Зөвшөөрлийн хуулиуд байна. Цаашлаад Татварын хууль байна, Нийгмийн даатгалын хууль байна гэх мэтчилэн их олон хуулиас хамааралтай. Маш олон оролцогчтой. Бизнес рүү хөрөнгө оруулж болохгүй гэсэн олон хаалтууд байна. 40 хэдэн салбарт 40 хэдэн төрлийн үйл хэрэгт хөрөнгө оруулалт оруулахыг хориглоно ч гэдэг юм уу. Тэгээд энэ дээр бид яг төлөвлөгөөт ажлуудаа төлөвлөгөөнийхөө дагуу хийнэ. Удахгүй энэ асуудлууд Монголын парламентаар хэлэлцэгдээд явна.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүнд микрофоныг нээе.

Д.Энхтүвшин: Эдийн засгийг солонгоруулах бол бидний эдийн засгийн улсын бол чухал зорилтуудын нэг гэж бодож байна. Тэгээд яг энэ салбар луу энийг уг нь томрох тусмаа уул уурхайн бус салбар томрох тусмаа бид нарын энэ уул уурхай тойрсон улс төр хийрхэл энэ олон зүйлүүд байхгүй болж, илүү урагшаа ажлаа хийдэг энэ бололцоо боломжууд бий болох юм. Тэгэхээр зарчмын хувьд энэ зах зээлүүдийг нээх нь зөв гэж бодож байгаа. Тэгэхдээ цаг хугацааны хувьд ААН-үүд маань бэлэн байна уу гэдэг дээр асуултын тэмдэг байгаад байгаа юм. Жишээлбэл татварын өр 4,7 их наяд жишээлбэл татварын өр, татвар, нийгмийн даатгалын өр ингээд нэмэгдчихсэн байна өнгөрсөн оны сүүлийн байдлын тоогоор. Энэ нь өнгөрсөн оныхоос 2023 оныхоосоо бараг 50 хувиар нэмэгдчихсэн. Өөрөөр хэлбэл саяын хэлсэн гол экспортлогч байгаа ААН-үүд маань жижиг, дунд аж ахуйн нэгж байгаа. Эд нарын хувьд эдийн засгийн байдал нь улам доройтсон ийм цаг үед яг нөгөө талаас нь дэмжлэгүүд нэлээн байхгүй бол бид энэ 3 жилийн хугацаанд юу ч хийж чадахгүй өнгөрөхөөр иймэрхүү дүр зураг харагдаад байгаа.

Би тэгээд Гадаад хэргийн яам, Хөдөө аж ахуйн яамнаас хэдэн асуулт асууя. Энэ гол экспортын бүтээгдэхүүнийг хараад үзэхээр махтай холбоотой өр нь хамгийн том бидний өсөлт хийх бололцоотой салбар бол мах байгаа. Тэгэхээр махан дээр ОХУ-аас болон энэ Евразийн бүс яг хэлэлцээрт байгаа улсуудын гол тавьж байгаа юм бол тарифын бус хорио цээртэй холбоотой асуудлууд байгаа. Тэгээд энэ дээр жишээлбэл яг Монгол талаас ямар ажлууд одоо яг хийгдэж байгаа вэ энэ хорио цээрийг нь хангахын тулд? Нөгөө талаасаа жишээлбэл яг энэ дээр мах ийм, ийм шаардлагуудыг авчихвал ингээд авна гэсэн тодорхой хэмжээний хүлээлтүүд байгаа юу? Яагаад вэ гэхээр ОХУ чинь өөрөө маш том мах экспортолдог улс байгаа. Тэгэхээр манай хувьд энэ дээр ямаршуу ажлууд хийгдэж байгаа гэдгийг Хөдөө аж ахуйн яамнаас.

Гадаад хэргийн яамнаас өмнө нь энэ чиглэлээр Евразийн энэ хэлэлцээртэй холбоотойгоор судалгаанууд хийгдэж байсан. Тэгэхээр тэр судалгаануудыг нэлээн яах вэ хэдэн жилийн өмнө байсан ашиггүй байдалтай судалгааны дүнгүүд гарч байсан. Тэгэхээр саяын энэ хэлэлцээрүүдийн өөрчлөлтүүдийн явцад энэ байдал яаж сайжирсан бэ? Энэ дээр дахиж та хэд судалж үзсэн зүйл байгаа юу? Дараа нь Гадаад хэргийн яамнаас төлбөрийн асуудал ОХУ руу хийх төлбөрийн асуудал улам хүндэрсээр байгаа. Тэгэхээр энэ дээр жишээлбэл энэ төлбөрийн асуудлуудыг яаж шийднэ гэсэн бодолтой байгаа вэ? Дээр нь Оросын талаас яг энэ төлбөрийн асуудлууд дээр яаж шийднэ гэсэн хүлээлтүүд байгаа вэ? Дараа нь Гадаад хэргийн яамнаас зарим улсууд энэ жишээлбэл Узбекистан ч юм уу, зарим улсууд энэ Евразийн энэ хэлэлцээртэй холбоотойгоор бусад улсуудтай, бусад улстай байгуулах хэлэлцээрүүд нь зөрчилдөөн үүсээд татгалзаж байсан ийм жишээнүүд байгаа харагдсан. Тэгээд Солонгостой бас хэлэлцээр хийхээр ажиллаж байгаа. Тэгэхээр энэ Евразийн хэлэлцээр дээр.../минут дуусав/

Л.Соронзонболд: Нэмэлт 1 минут Энхтүвшин гишүүнд.

Д.Энхтүвшин: Евразийн энэ гэрээ маань ойрын үед хийхээр төлөвлөж байгаа ч юм уу, яриа хэлэлцээ нь эхэлчихсэн энэ хэлэлцээрүүд дээр зөрчилдөх болон эсвэл бие биеийгээ улам нөхцөлдүүлж сайжруулах ямаршуу нөхцөлүүд байгаа вэ? Энэ талаар мэдээлэл өгөөч.

Л.Соронзонболд: Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 5 номерын микрофоныг нээе.

Ц.Болорчулуун: Энхтүвшин гишүүний асуултад хариулт өгье. Тэгэхээр ер нь энэ Евразийн чөлөөт худалдааны түр хэлэлцээртэй холбоотойгоор эдгээр орнууд руу энэ түр хэлэлцээрийн хүрээнд хорио цээрийн протокол тохирох асуудлыг нь нээлттэйгээр тавиад өгчихсөн байж байгаа. Ер нь урьдчилсан байдлаар энэ 5 улстай бид Монгол Улсаас мах экспортлох протоколыг тодорхой хэмжээнд манай Мал эмнэлгийн ерөнхий газар, холбогдох мал эмнэлгийн байгууллагуудтай тохиролцсон. Түүнчлэн ОХУ-тай бид урьд нь Монгол малыг эрүүлжүүлэх гээд 2 шаттай хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хөтөлбөрийг 3 дахь үе шатыг нь үргэлжлүүлж хэрэгжүүлье гэдэг байдлаар ОХУ Монгол Улсын ЗГ-ын хоорондын комиссын хурлын протоколд тусгаад, бэлтгэл ажлуудаа хангаад явж байгаа. Үүгээр мэдээж зөвхөн энэ гоц халдварт өвчинтэй холбоотой, шүлхий өвчний вакциныг сүүлийн 8 жилийн туршид ОХУ-аас тогтвортой худалдан авалт хийж, энэ малыг эрүүлжүүлэх чиглэлд онцгой анхаарч байгаа. Дээрээс нь энэ вакцины худалдан авалтыг үргэлжлүүлэх, түүнчлэн ОХУ-аас мэргэжлийн түвшинд энэ 2 улсын боловсон хүчнүүдийг харилцан сургах энэ асуудлууд дээр тодорхой хэмжээний ажлуудыг хийгээд явж байгаа гэж хариулъя.

Л.Соронзонболд: ГХЯ 7 номерын микрофоныг нээе.

Г.Өлзийсайхан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. ГХЯ Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал Өлзийсайхан байна. Өмнө нь энэхүү хэлэлцээрийг энэхүү холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг манай талаас 2015 оноос хойш Евразийн эдийн засгийн холбоо байгуулагдсан цагаас хойш ярьж байсан. Тэгээд 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Гадаад харилцааны сайд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалын дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлаад, хамтарсан судалгаа айлынхаа талтай хамтарч хийсэн гэсэн үг. Энэхүү судалгааны хүрээнд 7 бүлгийн асуудлыг авч хэлэлцээд, дүгнэж амжаагүй байхад нь Орос Украины нөхцөл байдал үүссэн байгаа. Тэрхүү урьдчилсан дүгнэлтийн үеэр Монгол Улсын талд экспортын орлого тасрах нь, татварын хөнгөлөлт, хөнгөлөлтийн хувьд ялангуяа нөгөө онцгой албан татварууд болон нэмүү өртгийн албан татваруудыг тэглэх.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гүйцээж хариулъя, 7 номерын микрофоныг нээе.

Г.Өлзийсайхан: Иймэрхүү асуудлууд үүссэн байсан. Тэгээд 2023 онд тухайн үеийн Эдийн засгийн хөгжлийн сайд Хүрэлбаатар энэхүү хамтарсан судалгаанаас Монголын тал гарч байгаа гэдгийг мэдэгдсэнээр энэ асуудал дууссан. Тэгээд энэний араас Эдийн засгийн хөгжлийн сайд Гантөмөрийн хэлж байгаагаар түр хэлэлцээр байгуулах асуудал ингэж үүссэн байдаг юм.

Төлбөр тооцооны асуудал дээр бид бүхэн нэг хэсэг нэлээн хүндрэлтэй байдалд орсон. Одоо бол бид холбогдох түншүүдтэйгээ холбогдоод Монголбанк, Сангийн яам, ГХЯ хамтран ажиллаад төлбөр тооцоо одоогийн байдлаар ОХУ руу жирийн явж байгаа. Одоо ч гэсэн Сангийн сайд Жавхлан АНУ-д болж байгаа Дэлхийн банк ОУВС-ийн хаврын уулзалтад оролцох үеэрээ АНУ-ын засаг захиргааны талтай энэхүү төлбөр тооцооны асуудлыг яаж цаашаа тогтвортой

явуулах вэ гэдэг асуудлыг ярьж байгаа гэж ойлгож болно. Солонгостой байгуулахаар ярилцаж байгаа, хэлэлцэж байгаа Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хувьд ажлын хэсэг.../минут дуусав/

Л.Соронзонболд: Хариултыг гүйцээе 7 номерын микрофоныг нээе. Товч хариулна шүү.

Г.Өлзийсайхан: Солонгостой хийж байгаа Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хувьд тус яам нь 4 ажлын хэсгийн дэд ажлын хэсэгт оролцоод ажиллаж байгаа. Гарал үүслийн дүрэм, хууль, эрх зүйн орчин, мөн барааны худалдааны хэсэг дээр ороод ингээд ажиллаад явж байгаа. Энэхүү хэлэлцээ 5 дахь удаагийнхаа үе шатын хэлэлцээг хийж дуусгасан байгаа. Ойрын хугацаанд зургаа дахь шатын хэлэлцээг хийнэ гэсэн ийм хүлээлттэй байгаа. Баярлалаа.

Л.Соронзонболд: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Болорчулуун даргаа тэгвэл ер нь энэ хэлэлцээр байгуулагдлаа л бол мах ямар ч асуудалгүй гарна гэж ойлгож болох уу 1 дүгээрт? Гадаад хэргийн яамнаас Өлзийсайхан даргаас өмнө түлштэй холбоотой асуудлууд дээр л онцгой хязгаарлалт нөхцөл өгөөч гэж олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай ярьж байна гэсэн бол одоо бусад асуудлууд дээр ч гэсэн яг адилхан байдлаар хөнгөлөлтүүд боломжуудыг нээж өгнө гэж хэлэлцэж байгаа гэж ойлгож болох уу?

Л.Соронзонболд: ХААЯ 5 номерын микрофоныг нээе.

Ц.Болорчулуун: Ер нь одоо байгаа нөхцөл байдлаасаа нөхцөл байдал мэдээж дээрдэнэ гэсэн үг. Яагаад гэвэл энэ Евразийн чөлөөт худалдааны түр хэлэлцээрийг байгуулснаар энэ 5 оронтой нөхцөл байдал дээрдэх ийм боломж үүсэж байгаа. Тэгэхээр махны экспорт дээр энэ ямар нэгэн асуудалгүй нэмэгдээд явах ийм боломж байна гэж харж байгаа.

Л.Соронзонболд: 7 номерын микрофоныг нээе ажлын хэсгийн.

Г.Өлзийсайхан: Энхтүвшин гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Төлбөр тооцооны асуудал дээр Монгол Улсын хувьд Европын холбоо, АНУ болон бусад улс орны зүгээс тавьсан эдийн засгийн санкцын улмаас ОХУ руу хийх төлбөр тооцоо бол асуудалтай бол байсан. Айлын талтайгаа бусад түншүүдтэйгээ ажилласны хүчинд мэдээж шатахуун, эрчим хүч, мөн хүмүүнлэгийн бараа, бүтээгдэхүүн болох эм, эмийн хэрэгсэл, хоол хүнс дээр бид төлбөр тооцоог одоогоор саадгүй явуулж байгаа. Цаашид энэ саадгүй явж байгаа төлбөр тооцооныхоо энэ сувгийг сунгах шаардлага байгаа. Энэ дээр бид хамтран ажиллаж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Л.Соронзонболд: Шижир гишүүний микрофоныг нээе.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Асуултууд давхцаж байгаа учраас зарим юмыг товчлоод асуучихъя. 1 дүгээрт Гадаад яамнаас яг энэ Евразийн чөлөөт худалдааны түр хэлэлцээрт ороход ямар байр суурь илэрхийлж, яг энэ гэрээ дээр ямар, ямар тодорхой саналууд өгч байсан бэ гэдэгт нэг тодорхой хариулт өгөөч.

Хоёрдугаарх нь яагаад энийг асуугаад байна вэ гэхээр 2016 онд Японтой чөлөөт худалдааны хэлэлцээр хийгээд, манайхаас экспортлох бүтээгдэхүүн байгаагүй байхгүй юу. Яагаад гэвэл тэдний стандартад нийцэх бүтээгдэхүүн бидэнд байгаагүй юм. Тэгэхээр яг одоо энэ Евразийн 5 улс руу бид ямар нэгэн байдлаар зах зээлээ тэлээд өөрсдийнхөө үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортоллоо гэхэд стандартын зөрүү хэр байгаа вэ энэ улсуудтай? Манай бүтээгдэхүүн шууд энэ 5 улсын стандартыг хангаж байгаа юу, энэ дээр хийсэн судалгаа байгаа юу гэдгийг Гадаад яамнаас асууя.

2 дугаарт Худалдаа, аж үйлдвэрийн танхим дэмжиж байгаа гэдэг байр суурь илэрхийлж байна. Дэмжиж байгаа бол та нар 2 зөвлөгөөн хийсэн гэж би сонслоо. Судалгаа авсан уу? Авсан бол хэчнээн ААН-үүдээс яг энэ чиглэлийн 375 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хэдэн ААН байгаад тэднээс хэдээс нь хэдэн удаагийн судалгаа авч нэгтгэчихсэн бэ гэдэг асуулт.

Гуравдугаарх нь энэ Евразийн чөлөөт худалдааны хэлэлцээрт орсон 5 улс хоорондоо төлбөр тооцооных нь 75 орчим хувь рублиэр хийдэг юм байна. Тэгээд манайх рублиэр хийх юм уу, доллароор хийх юм уу? Энийг тодорхой хариулаад өгөөч. Ийм 3 асуулт байна.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 9 дэх микрофон уу? Хэн хариулах вэ ажлын хэсэг дээр Шижир гишүүний асуултад? 7 номер.

Г.Өлзийсайхан: Шижир гишүүний асуултад хариулъя. Манай ГХЯ-наас хэлэлцээрийн төсөл дээр холбогдох саналуудыг тухай бүрд өгч явсан байгаа. Хамгийн сүүлд 24 оны 10 сарын 29-ний энэхүү саналыг би танд товчхон дурдъя. Олон улсын гэрээний тухай хуулийн заавал соёрхон батлах Олон улсын гэрээний тухай хуулийн процедурыг дагах. Мөн Монгол хэлнээ орчуулж төрийн захиргааны төв байгууллагад орчуулгыг хянуулах, хэлэлцээрийн нэршлийг нэг талдаа гарах. Мөн Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн дагуу худалдааны аливаа хориг, хязгаарлалтыг хэрэглэхгүй байлгах энэ зохицуулалтыг хэлэлцээний түвшинд оруулах, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж байгаа Хүнсний аюулгүй байдлыг хангах, мөн Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа энэ хөтөлбөрүүдийг бараа, бүтээгдэхүүнүүдийн хэлэлцээрт заавал тусгах, мөн гарал үүслийн дүрэм дээр Монгол Улсаас гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүний хэмжээг 40 хүртэл хувиар байх зэрэг хэлэлцэн тохирох асуудлуудыг бид санал хүргүүлсэн байгаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 9 дэх, 9 номерын микрофоныг нээе.

Д.Төр-Од: Шижир гишүүний асуултад хариулъя. Танхимаас нийтдээ ер нь нөгөө чөлөөт худалдааны хэлэлцээр эдийн засгийн иж бүрэн түншлэлийн асуудлаар 2 хэлэлцүүлэг, Евразийн эдийн засгийн түр хэлэлцээрийн төслөөр 1 том хэлэлцүүлэг, тэгээд салбар салбарын жишээлбэл танхимаас бид үндэсний үйлдвэрлэгч гол экспортын бүтээгдэхүүн болох 3 салбарт хамгийн чухал ач холбогдол өгч энэ дээрээ ажиллаж байгаа. Нэгд нь мэдээж хэрэг мах махан бүтээгдэхүүн, 2 дугаарт арьс ширэн бүтээгдэхүүн, 3 дугаарт Цагаан алт байгаа. Өөрөөр хэлбэл ноос ноолуур болон ер нь нөгөө малын гаралтай бүтээгдэхүүн. Тэгээд бид сүүлийн хугацаанд нийтдээ яг нөгөө манай томоохон болон дунд, жижиг бизнес эрхлэгч экспортлогчдын нийтдээ 500 гаруй ААН-ээс санал нэг бүрчлэн авсан

байгаа. Танхим нь угаасаа нийтдээ 6500 гаруй гишүүнтэй, үүнээс энэ 500 гаруй ААН экспортлогчдоос бид 250.../минут дуусав/

Л.Соронзонболд: Тэр төлбөрөө ямар валютаар хийх вэ гэж асуусан. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн хэдэн номер хариулах вэ? Төлбөрөө ямар валютаар хийх вэ гэсэн. 4 номер.

И.Батхүү: Евразийн эдийн засгийн холбоотой байгуулж байгаа Чөлөөт худалдааны түр хэлэлцээрийн хүрээ бол барааны тодорхой хэмжээний хязгаарлагдмал жагсаалтаар хязгаарласан, үйлчилгээний болон бусад салбаруудын асуудлыг огт хөндөөгүй. Төлбөр тооцооны валютыг тухайлан зааж өгөөгүй. Яг гадаад худалдаа эрхлэгчид хоорондоо тохиролцож байгаа тэр хэлбэрээрээ явж байгаа.

Л.Соронзонболд: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Танхимаас дахиад тодруулчихъя. Тэгэхээр тэр 375 төрлийн бараа, бүтээгдэхүүнийг Монголд үйлдвэрлээд байгаа ААН-үүдийн 500 гаруй төлөөллийг уулзуулаад бүгдээрээ дэмжсэн гэж та хэлж байна зөв үү эхнийх нь?

Хоёрдугаарх нь төлбөр тооцооныхоо валютыг тохироогүй бол төлбөр тооцоогоо рублиэр хийнэ гэвэл яах вэ? Яагаад энийг асуугаад байна вэ гэхээр энэ Евразийн чөлөөт худалдааны хэлэлцээрт орсон нэгдсэн улсууд чинь нийт 75 хувиа рублиэр хийдэг юм байна шүү дээ рублиэр. Тэгэхээр манайхыг дахиад ингээд төлбөр тооцоо рублиэр хийнэ гэвэл яах вэ? Энэ дээр ингээд тодорхой заахгүй орхичихоор энэ чинь эрсдэл биш үү?

Тэгээд би Гадаад яамнаас дахиад тодруулъя. Зүгээр яах вэ процедур дээр нь оролцсон гэж байна. Яг энэ гэрээ дээр нь яг тусгайлан саналууд өгөөд явсан ийм зүйлүүд байгаа юм уу? Яг энэ, энэ заалтууд, энэ, энэ бүтээгдэхүүнүүд гэсэн юмнууд дээр, процедур дээр биш.

Л.Соронзонболд: 9 номерын микрофон ХАҮТ.

Л.Төр-Од: Шижир гишүүний нэмэлт асуултад хариулъя. Нийтдээ би хэлсэн 500 ААН-ээс 250 бараа, бүтээгдэхүүн гол жагсаалтыг бид гаргаж өгсөн байгаа. Гол нь дэмжих. Эргээд энэ дээр 3, 4-хөн бараа бүтээгдэхүүн дээр асуудал байсан. 1 дүгээрт өндөг байсан, 2 дугаарт буудай, 3 дугаарт архи болон амуугаар исгэсэн пиво буюу шар айраг, 4 дэх нь тамхи асуудал. Тийм учраас энэ энэ 4-ийнхөө асуудлыг бид Эдийн засаг, хөгжлийн яам, эргээд бид Евразийн эдийн засгийн комисстой уулзсан. Эргээд танхимаас нөгөө эдгээр 5 улсынхаа ХАҮТ-уудын дарга нар болон холбогдох улсуудтай уулзаад, бид саяын эцэслэсэн сүүлийн хувилбар дээр яг ААН байгууллагуудынхаа саналаар 8 барааг хасаад, 23 бараан дээр өөрчлөлт оруулсан байгаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номер. Шижир гишүүний асуултад хариулъя, 9 номер хариулах юм уу? Ажлын хэсгийн 9 номерын микрофоныг нээе.

Л.Төр-Од: Ганбаатар гишүүний нэмэлт асуултад хариулъя. Тухайлбал өндөг дээр бид квот тогтоож байгаа. Эргээд зөвхөн нөгөө тариф дээрээ 25 хувийн хөнгөлөлтүүд нөгөө бусад бараан дээрээ өгч байгаа. Онцгой албан татвар эд нар

бол хэвээр байгаа. Тэгээд өндөг дээр жишээлбэл нийт 8 ААН байгаа. Эдгээрт эргээд импортлох буюу Евразийн эдийн засгийн холбооноос орж ирүүлэх тэр импортлогч эрхийг нь олгохоор бид ийм шийдэлд хүрсэн байгаа тухайлбал.

Л.Соронзонболд: Төлбөр тооцоон дээр рублиэр 75 хувь нь явдаг юм байна шүү дээ одоогийн холбооны гишүүдийн хооронд. Монголд ингээд тодорхойгүй байлгах нь эрсдэлтэй юм биш үү гэж асуулт асуусан шүү дээ. Энэ дээр 4 номер хариулах уу?

И.Батхүү: Тэгэхээр энэ олон улсын гэрээнд гэрээний чөлөөт байдлын зарчим гэж байгаа. Иргэд, ААН-үүдийн хооронд хийж байгаа, хувийн хэвшил хоорондын гэрээг энэ олон улсын хэлэлцээрээр шууд хатуу зааж хязгаарлаж зохицуулах боломжгүй байгаа.

Л.Соронзонболд: Гадаад харилцааны яам 7 номерын микрофон нээе.

Г.Өлзийсайхан: Шижир гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Бидний хувьд зөвхөн процедур биш хэлэлцээний сүүлийн раунд буюу Москвад Гантөмөр сайдын ахалж явсан ажлын хэсэг дээр орж ажилласан байгаа. Тэгээд тухайлбал ямар саналууд өгсөн гэхээр төслийн 5 дугаар зүйл дээр экспортын татвартай холбоотой зохицуулалтыг, төслийн 8 дугаар зүйлд түрүүн хэлсэн хориг тоон хязгаарлалтын арга хэмжээ, төслийн 28 дугаар зүйлийн 3 жилийн хугацаатай үйлчлэх хугацааны асуудлыг, төслийн 28 дээр мөн 6 сарын дараа хүчингүй болохоор энэхүү хэлэлцээрийг хэрхэн цуцлах талаар процедур зэрэг саналуудыг тодорхой өгсөн байгаа.

Л.Соронзонболд: Шижир гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ө.Шижир: Миний нэг асуултад хэн ч хариулсангүй. Нөгөө бусад 5 улстай чинь стандартад нийцэх юм уу манайд бүтээгдэхүүн дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд гэж байгаа юм буцаад экспортлоход? Яагаад гэхээр Япон руу бид зөндөө юм экспортолъё гээд маш олон дээж явуулсан ч тэдний стандартыг хангаагүй байхгүй юу. Хангаагүй болохоор бид экспортолж чадахгүй байгаа юм. Тэгээд зөрүүлээд Японы юм манай стандарт хангачихдаг учраас тэднийхээс авч байгаа импорт нь 1,8 тэрбум доллар хүртэл нэмэгдчихсэн. Энэ дотор мэдээж автомашин дийлэнх хувийг эзлэх байх л даа. Гэхдээ 1,8 тэрбум доллар 400-аас 1,8 тэрбум болтол нэмэгдчихсэн. Тэгээд манайхаас үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнүүд энэ 5 улсын стандартыг хангаж чадаж байгаа юм уу? Энэ дээр харьцуулсан судалгаа байгаа юу? Энэ дээр хэн ч хариулсангүй.

Л.Соронзонболд: Хэн хариулах вэ? 9 номерын микрофоныг нээе.

Л.Төр-Од: Шижир гишүүний нэмэлт асуултад хариулъя. Үндэсний танхим нь яг салбарын яамд, засгийг төлөөлөөд ер нь экспортын барааны бүх гарал үүслийн гэрчилгээ certificate of origin, 2 дугаарт экспертиз магадлан итгэмжлэлийн гэрчилгээг олгож байгаа. Өөрөөр хэлбэл стандартад хангасан байна уу, үгүй юу. Тийм учраас бид түрүүн хэлсэн. Нийт хоёр зуун бараг наян бараа таваар нь бүрэн хангаж байгаа. Өөрөөр хэлбэл угаасаа одоо экспортолж байгаа барааны жагсаалт орсон байгаа гэсэн үг энэ 367 жагсаалт дээр. Эргээд сая 12 дугаар сард Үндэсний танхимаас энэ Евразийн Эдийн засгийн холбооны түр хэлэлцээрт бэлтгээд бид Оросын гаальтай

протокол байгуулсан байгаа. Нэгдсэн системд нь орох, эргээд стандартыг хангах. 2 дугаарт бидний үндэсний танхимын санаачилгаар Шадар сайд.../минут дуусав/

Л.Соронзонболд: Батболд гишүүний микрофоныг нээе.

Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Ер нь манайх чинь нэг Худалдааны хууль гэж юм байхгүй. Дээрээс нь энэ бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоогоо шийдэж чадаагүй байж л хамаагүй энэ нөгөө худалдааны хэлэлцээр лүү яваад байх шиг санагдаад байгаа юм. Зүгээр энэтэй холбоотой энэ Гантөмөр сайдаас Эдийн засгийн хөгжлийн яамнаас, Гадаад яамнаас хэдхэн асуулт асуучихъя. Тэгэхээр энэ бид чинь энэ гэрээг худалдааны гэрээг 3 жилийн түр гэрээ гэж яриад байдаг. Сайд ярихаараа үгүй ээ энэ чинь цаашаа дахиад явах юм шүү дээ гээд байдаг. Энэ чинь тэгээд түр гэрээ юм уу, яг нэг мөр орж байгаа юм шиг ингээд явчих юм уу гэдэг ийм нэг асуудал гараад байна. Нөгөө Гантөмөр сайдын хариултаас нь. Тэгэхээр энийг нэг хариулж өгөөч. Үнэхээр бид яг ингээд түр гэрээ гэдэг нэрээр орчхож байгаа юм уу эсхүл зүгээр 3 жилийн дараа больё энэ арай болохгүй юм байна, манайд арай тохирохгүй байна хойшлуулъя гэдэг юм уу ийм байдлаар явж болох юм уу гэдэг нэг асуудал.

Тэгээд энэ маань өөрөө, 2 дахь асуулт нь. Гэрээ маань өөрөө энэ Европын холбоотой хийсэн, Японтой хийсэн энэ худалдааны хэлэлцээрээс гэрээнээс сайжирсан юм уу эсвэл яг тэр хэвээрээ л яваад байгаа юм уу гэдэг асуудал.

3 дугаар асуудал худалдааны хэлэлцээрт орчихлоо гэхэд энэ бид нарын энэ гаргах гээд байгаа нийлүүлэлтийн тогтолцоо чинь яг бэлэн юм уу? Бид яг ирэх жилээс махаа яг гаргаад 600 сая доллар олно гээд байдаг энийгээ олох юм уу? Арьс шир, түүхий эд чинь яг бэлэн юм уу, хэн тэрийг нийлүүлэх гээд байгаа юм бэ, хааш нь энэ 5 улс руугаа хэн гаргах гээд байгаа юм бэ, энэ чинь бэлэн юм уу гэдэг нэг асуудал байна. Энэ нийлүүлэлтийн тогтолцоо маань яг ямар байх юм бэ? Тэгээд жоохон итгэл үнэмшил өгмөөр байх юм. Одоо бид дотоодын үйлдвэрлэгч нараа хамгаалъя гэж яриад байдаг. Тэгэхээр энэ холбоод маань яг юу гэсэн юм бэ? Энийг бид Эдийн засаг, хөгжлийн яаман дээр ажиллахдаа ч гэсэн энэ уулзуулаад өгөөч, наадуул чинь яг зөвшөөрөөд байгаа юм уу, болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу? Энэ үндэсний үйлдвэрлэгчид хариуцсан тэр холбоод чинь энийгээ дэмжээд байгаа юм уу, үгүй юм уу гэдэг дээр нэг уулзалт зохион байгуулаад өгөөч гэсэн бас ийм итгэл үнэмшил төрүүлэх юм ерөөсөө хийгдэхгүй байгаад байдаг.

Дээрээс нь энэ түрүүн хэлж байна, Номинчимэг гишүүн хэлсэн үү? Тамхины татвартай холбоотой юм яригдаад байдаг. Гурилаа 50 мянган тонноор бид импортолно гэж яриад байдаг. ХААЯ яг ямар бодлого бариад байгаа юм бэ? Бид чинь энэ улаан буудайгаа ер нь 100 хувь хангачих боломжтой байгаад байсан биз дээ? Энэ 50 мянгаар нь ингээд явуулаад бид заавал импортлох ийм үүрэг хүлээгээд явчих юм уу, яах юм гэдэг нэг асуудал.

Эцэст нь энэ Гадаад яамнаас асууя. Энэ хэлэлцээрт орсноор бид Европын холбооноос хоригт орчих юм биш биз дээ гэдэг нэг. Энэ чинь ОХУ орчихсон ийм.../минут дуусав/

Л.Соронзонболд: Батболд гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Р.Батболд: Тэгэхээр Гадаад яам энийг нэг хариулж өгөөч. Бид Европын холбооноос ямар нэгэн эсэргүүцэл, ямар нэгэн санкцад орчих юм биш биз дээ гэдэг ийм хэдэн асуулт байна.

Л.Соронзонболд: Гантөмөр сайдын микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Батболд гишүүний асуултад хариулъя. Хэлэлцээр түр хэлэлцээр 3 жилийн хугацаатай. 3 жилийн дараа дахиад 3 жилээр сунгаж болно, зогсож болно. Таны хэлдгээр 3 жилийн дараа больё гээд больж болох уу гэж болно. Бид Евразийн эдийн засгийн холбоонд гишүүнээр ерөөсөө элсэхгүй. Ажиглагч гишүүн гэж хүртэл байдаг юм байна лээ. Тэрэнд элсэхгүй шүү гишүүнээ. Тийм учраас та Евразийн эдийн засгийн холбоо руу бид ингээд яваад орчхож байгаа юм байна гэдэг төсөөллөө бүрмөсөн авч хаяарай гэж би бүх гишүүдэд тэрийг хэлмээр байгаа юм. Тэр төсөөллөө бүрмөсөн авч хаяарай.

Энэ худалдааны хэлэлцээр Японтой харьцуулахад маш цомхон. Японтой жишээлбэл 6 мянга, 9 мянган барааны тухай ярьж байгаа бол бид Евразийн эдийн засгийн холбоотой 367 бараа ярьж байгаа, 20 дахин жоохон гэсэн үг. Экспортлох бараан дээрээ 30 дахин жоохон гэсэн үг. Тэгэхээр асар цомхон хэлэлцээрийг хийж, бид өөрийнхөө үйлдвэрлэж чадаж байгаа бүтээгдэхүүнээ л тэр 375 бүтээгдэхүүн гэж үзсэн юм. Тэрнээсээ хасуулаад одоо 367. Манайхан оёж байгаа, хатгаж байгаа гээд. Тэгээд энэ улсууд бид энэ барааг хийж байгаа л гэж байгаа юм. Энийгээ хийж байгаа учраас энийгээ татварын хөнгөлөлт эдэлж байгаад зарчихъя л гэж байгаа юм. Ийм асуудал байгаа юм. Түүнээс айхтар бэлдээд л хивсний Улаанбаатар хивс компани дээр нэмэлт бэлтгэл хийх, Говь ноолуур дээр нэмэлт бэлтгэл хийх, Ханбогд кашмер дээр нэмэлт бэлтгэл хийх, Мах импекс дээр нэмэлт бэлтгэл хийх ч гэдэг юм уу ийм зүйлээсээ илүүтэйгээр манайхан үйлдвэрлэж байгаа бараагаа энэ зах зээлд зориулаад тэр хаяг шошго юу байдаг юм юмыг нь өөрчлөөд ингээд гаргая гэсэн нэг ийм хэлэлцээр явж байгаа шүү. Өөр хэнээс асуулаа Батболд гишүүнээ?

Л.Соронзонболд: Гадаад харилцааны яам 7 номер.

Л.Гантөмөр: Тэр мэргэжлийн холбоодын хувьд ер нь холбоод нь ороод би түрүүн хэлсэн нөгөө бараа бүтээгдэхүүнтэй холбоотой 25 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг би тушаалаараа гаргасан юм. ХААЯ-ны ТНБД-аар ахлуулаад. Тэгээд ХААЯ бүгдийг нь сонссон, бүгдтэй нь ярианд орсон. Тэгээд тэр улсууд тэр холбоод бол өөр өөрийн гэсэн байр сууриа илэрхийлээд, тэр нь хэлэлцээр хийж дуусаад, дэмжиж байна гэдэг ийм ойлгомжтой хариу байгаа гэж ойлгож байгаа. Мөн үү? ХААЯ бол би сүүлд яг Москвад байж байхдаа хэлэлцээр хийхдээ би Энхбаяр сайдтай өөртэй нь утсаар ярьсан. Би яг энэ түвшинд ингээд тохиролцоонд хүрэх нь байна шүү гэдэг зүйлээ хэлсэн. Энхбаяр сайд энийг манай дэргэд байгаа Хүнс үйлдвэрлэгчдийн холбоо бүгд хүлээн зөвшөөрч байгаа гэж ингэж надад мэдээлэл өгсөн шүү. Баярлалаа.

Л.Соронзонболд: Хүнс, хөдөө аж ахуйн яам 5 номерын микрофоныг нээе, хариулт.

Ц.Болорчулуун: Батболд гишүүний асуултад хариулъя. 375 бүтээгдэхүүний хэлэлцээр дээр суугаад, мэргэжлийн 25 холбоодын оролцсон энэ ажлын хэсгийн хуралдааныг 3 удаа зохион байгуулсан. Энэ ажлын хэсгийн гишүүн мэргэжлийн холбоодоос гарсан саналын дагуу 23 төрлийн бүтээгдэхүүнийг хасуулах саналтай

байна гэдэг ийм саналыг хүргүүлсэн. Энэний 2 дахь удаагийн саналаар нь сүүлийн хэлэлцээрээр улаан буудайн дээр 50 мянган тонн улаан буудайг 3,75-ыг нь татвартай оруулъя гэдэг хамгийн сүүлийн санал ирсэн байгаа.

Л.Соронзонболд: Гадаад харилцааны яам 7 номер микрофон нээе.

Г.Өлзийсайхан: Батболд гишүүний асуултад хариулъя. Европын холбооны хориг гэдэг нь өөрөө бид Европын холбоотой таны түрүүний дурдсан 7200 бараа бүтээгдэхүүн татваргүй экспортлох худалдааны хөнгөлөлтийн систем буюу GSP plus гэж нэг ярьсан хөнгөлөлтийн системийг эдэлдэг. Энэхүү хөнгөлөлтийн системийн дагуу бид бараагаа экспортын татваргүй гаргадаг боловч эргээд 27 төрлийн хүний эрх, хөдөлмөрийн эрх болон бусад авлигатай тэмцэх зэрэг олон улсын гэрээ конвенцын хэрэгжилтийг тайлагнадаг байгаа. Евразийн эдийн засгийн холбоонд Вьетнам, Иран болон Серб улсуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан байна. Арабын нэгдсэн Эмират, Индонез, Египет, Израил зэрэг улсуудтай чөлөөт худалдааны хэлэлцээ хийхээр 4-өөс 7 жилийн хугацаатай хэлэлцээ хийгээд явж байгаа. Тэгэхээр энүүгээр эдгээр улс нь бүгдээрээ Европын холбоотой дипломат харилцаатай, эдийн засгийн харилцаатай байдаг болохоор энэ дээр одоогийн байдлаар Европын холбооноос ямар нэгэн асуулга асуудал тавиагүй. Бид.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гишүүд асуулт асууж дууслаа. Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Лодойсамбуу гишүүн, Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ Европын холбоо, Японтой чинь 2014 онд Гантөмөр сайдаа хийсэн, тэгээд ингээд тоог нь харж байгаа байх та мэдээж танай яамныхан гаргаж өгсөн байх. Тэгээд 2014 онд манай экспорт 24 сая байсан бол өнөөдөр 12 сая болсон. Тэгээд түрүүн Шижири гишүүн хэлсэн. Дөнгөж одоо бид нэг импорт нь 300 байсан бол буцаад бараг 1 тэрбум 200 сая. Европын Холбоо бол экспорт 104, 100 гардаг байсан бол одоо 90. 10 жилийн дотор шүү дээ. Экспорт нь, импорт нь 2 дахин өсчихсөн, бүр даблдаад тэрбум. Ийм битгий болоосой л гэж хүсэж байгаа юм, ийм битгий байгаасай гэж хүсэж байгаа юм. Тэгээд энийгээ ядаж нэг тэнцүүлээд юм уу, дөхүүлээд Хөдөө аж ахуйн яамаа. Баахан архи живүүлэв дээ. Монгол Улсын Ерөнхийлөгч архины талаар том хууль санаачлаад 2, 3 хууль хэлэлцэгдээд батлагдчихсан явж байгаа шүү. Өнөөдрийн тэр хойд талын Алтанбулаг гээд чөлөөт бүс чинь зүгээр архи зардаг л тийм газар. Тэгээд энэ Хөгжлийн банктэй холбоотой нэлээн олон хүний хариултад гарлаа. Эдийн засгийн сайдын юугаар ч гарлаа, тэр хариулж байгаа ажлын хэсгээс ч гарлаа. Тэгээд Хөгжлийн банкаа дөнгөж цэгцлээд дуусаж байгаа шүү дээ. Эдийн засгийн яамныхандаа нэг анхаараарай энэ 4 номер, 3 номер. Гантөмөр сайдад сануулж хэлж байх хэрэгтэй шүү.

Тэгээд би тэр 4 номерын юунд хэлж байгаа тэр Төрийн нарийн бичгийн даргаа. Энэ Хөгжлийн банкны чинь асуудал маш чухал шүү. Дөнгөж цэгцэрч байгаа буцаад Хөгжлийн банк гээд нэг ийм баахан зээл олгоод ингээд. Гантөмөр сайд түрүүн над руу ганц, хоёр үг зүгээр сайхан дотор нь шургуулаад хэлэх шиг боллоо. Миний хувьд уучлаарай төртэй бизнес хийж үзээгүй шүү. Цаашдаа ч хийх сонирхол байхгүй, шаардлага байхгүй. Нэг ч удаа тендер авч үзээгүй, авах ч шаардлага байхгүй. Уучлаарай. Тийм нэг их тэгж, тэгдэггүй бизнесменүүд зөндөө байгаа шүү дээ. Заавал тэгж амьдрах шаардлага байхгүй шүү дээ. Ганбаатарын ард зөндөө юм

байгаа гээд бараг 7, 8 жил олон хүмүүс араас явсан юм. Тэгээд ганц, хоёр гүтгээд л юман дээр бичдэг юм. Гүтгэлээ гээд тэгээд би нэг их өөрчлөгдөхгүй л дээ. Зүгээр сануулж хэлж байгаа шүү. Сайхан болоосой гэж санаа зовж байгаа юм, сайжраасай. Энэ хэлцэл Монголын ААН-үүдэд ашигтай байгаасай гэж хэлж байгаа юм шүү. Үг хэлэхлээр тэр тэгчихсэн байх, ингэчихсэн байх, тэр ингэсэн байна, энэ ингэсэн байна, тийм юм байхгүй. Би Байнгын хорооны дарга болохгүй, сайд ч болохгүй. Аливаа асуудал сайжраасай л гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Л.Соронзонболд: Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе.

О.Цогтгэрэл: Түрүүн хэлсэн энэ бол түр хэлэлцээр. Түр гэдэг чинь өөрөө туршилтын 3 жил гэж ойлгож байгаа. Тэгээд бэлээхэн туршилтууд маань ямар үр дүнтэй байгааг бид тоог нь харсан, үзсэн. Үнэхээр Японтой хийсэн, Европтой хийсэн хэлэлцээрүүд ямар ч л байсан асар их тийм хүссэнээс сөрөг үр дүн гарчихсан байгаад бид ингээд дүгнэлтгүй л явж байгаа. Бүр шоглоомтой юм шиг нэг жилийн өмнө ОХУ-тай хийсэн 2 бүтээгдэхүүн дээр гурилан дээр, малын тэжээл дээр хийснийг өнөөдөр буцаж татвар тавих тухай өнөөдрөөс эхлээд Улсын Их Хурлаар Байнгын хороодоор хэлэлцэгдэж эхэлж байгаа өнөөдрөөс. Тэгэхээр энэ бол үнэхээр бодит байдал ямар байгааг харуулж байна. Тэгээд түрүүн экспортын боломж дотор махан дээр их хүлээлттэй байгаа гэдэг зүйлийг энэ хэлэлцээр ахалж байгаа хүмүүс мэргэжлийн ийм багийнхан хэлж байна лээ махан дээр.

Гэтэл ХААЯ-ны газрын даргын хэлж байгаагаар ер нь тэр энэ тариф хөнгөлөлт яах вэ, ямар ч байсан тэр хорио цээр дээр бид өнөөдөр ямар ч шийдэл гараагүй, сайжруулахаар ажиллаж байгаа гэдэг үгийг би сонслоо. Тэгэхээр татварын асуудлаасаа урьдаар тэр хорио цээр, малын халдварт өвчний асуудлаа алийг нь ч шийдээгүй энэ хэлэлцээр хийгээд эхэлчихдэг. Нөгөө мах нь татваргүй байсан ч, үнэгүй байсан ч бараг нөгөө айл чинь авахгүй ийм нөхцөлтэй нь тарифын бус хориг саадууд нь шийдэгдээгүй байхад энэ хэлэлцээр цаг хугацааны хувьд оновчтой юм уу гэдэг ийм л нөхцөл байдал дээр тулж ирж байна л даа. Тэгэхээр хэлэлцээрийг хэлэлцээрийн хувьд цаг хугацааны хувьд энэ маань тэр махныхаа хорио цээр, халдварт өвчний асуудал, олон улсын стандартын асуудал энэ олон зүйлээ яаравчлах энэ асуудлаа шийдэж байж энэ хэлэлцээр чинь эхэлбэл Монгол Улсын хувьд энэ үндэсний эрх ашгийн чинь хувьд илүү зохистой ийм нөхцөл байдал шууд л ингээд энэ хэлэлцээрээс харагдаж байна л даа. Тэгээд хэрвээ цааш явлаа гэхэд нөхцөл байдлыг цаг хугацаа харуулах нь байна. Цаг хугацаа харуулахдаа, харуулах харуулахдаа бүүр үр дүн бараг тодорхой л байна л даа. Үр дүн тодорхой. Тэгээд энэ дээр хэлэлцээр хийж байгаа хүмүүс энэ олон хүмүүс ингээд цаг хугацааныхаа хүчин зүйлийг илүү анхаарна биз.

Л.Соронзонболд: Жаргалан гишүүний микрофоныг нээе.

Б.Жаргалан: Юуны өмнө нэг зүйлийг хэлэхийг хүсэж байна. АН Монгол Улсыг дэлхийд нээлттэй болгох, бүх дэлхийтэй худалдаа наймаа хийх боломжийг нээсэн, үүний төлөө тэмцсэн, дэлхийн улс орнуудтай эрх тэгш харилцаатай байхыг эрхэмлэж ирсэн ийм улс төрийн хүчин. 2 хөрштэйгөө ч эн тэнцүү эрх тэгш зарчмаар харилцдаг. Хамгийн гол нь үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөг эн тэргүүнд эрхэмлэдэг ийм улс төрийн нам шүү Гантөмөр даргаа. Харин ямар ч аль нэг талыг нь баримталж чадлан эсэргүүцсэн зүйл огтхон ч алга. Бид нэн тэргүүнд манай улсад энэ хэлэлцээр ашигтай юу, үгүй юу, Монголын үйлдвэрлэгч орлого олж чадах уу, үгүй юу, Монгол хүн ажилтай байж чадах уу, үгүй юу бид эдийн

засгаа тавиад туучихгүй юм биш биз дээ гэж санаа зовж байгаа учраас ийм зүйл яриад байгаа юм.

Бидний хувьд үнэхээр л Монгол хүн бүр ажилтай, орлоготой байхын төлөө л ажиллаж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд бид дотооддоо шийдэх асуудал маш олон байна. Гэтэл ЗГ-аас сүүлийн үед дандаа л ийм гадаад улсуудтай гаднын улс орнуудтай байгуулах ийм хэлэлцээрүүдийг л оруулж ирээд байна. Хэзээ бид дотоодынхоо асуудлыг шийдэх юм бэ? Хэзээ бид ААН компаниудынхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлэх энэ асуудлыг ярих юм бэ? Бид намрын чуулганаар бараг тэр чигт нь Ганцмод-Гашуунсухайтын боомтын хэлэлцээрийг яриад дууссан шүү дээ Хятадтай хийх асуудал. Тэгээд энэ хаврын чуулганаар энэ Оросын талтай хийх асуудлыг яриад л дуусаж байна. Дотоодын асуудлуудаа ярья л даа. Манайд чинь эдийн засаг гэж зүйл байхаа байчихаад байна. Бүх зүйл дээр нь төр орж ирж сандалд суучхаад, төрийн өмчит компаниуд дээр нь хамаг орлого төвлөрчхөөд манай энэ, манайд ер нь бараг ийм бизнес гэж нэрлэж болох зүйл байхгүй болчихоод байна шүү дээ. Тэгээд энэ бол тэр бизнес эрхлэгчдийн буруу биш шүү дээ. Төрийн л буруу шүү дээ.

Тэгээд өнөөдөр ч гэсэндээ өнөөдөр энд хэдэн улс төрчид суучхаад Монголын зах зээлийг нээх үү, эс нээх үү тухай яриад байх юм. Тэгээд тэр яг худалдаа наймаа хийх хүмүүсийнх нь овсгоо нь мэддэг юм байгаа биз гээд. Үгүй ээ тэгээд тэр овсгоотой байх эсэх тал дээр нь энэ улс төрчид чинь шийдвэр гаргах ёстой биз дээ? Бид энэ өрсөлдөх чадваргүй бизнесүүдийгээ ингээд ийм бүүр далай шиг юм руу хаячхаж болохгүй биз дээ? Тэр бүүр тэр улс төрийн геополитикийн асуудлыг энд хэн ч ярихгүй байгаад байна шүү дээ. Үнэндээ ахиад жилийн дараа баахан ийм хямд өртөгтэй бүтээгдэхүүн манай зах зээлээр нэг тарчихсан, манай компаниуд хаалгаа бариад эхлэхэд бид яах болж таарч байна. Түүн дээр итгэл өгч чадахгүй байгаад байна шүү дээ ажлын хэсгийнхэн. Тэгэхээр бид нарын гол асуудал бол дотоодынхоо үндэсний үйлдвэрлэгч нараа, дотоодынхоо зах зээлээ бодолцох. Ялангуяа энэ олон улсын нөхцөл байдал ийм ээдрээтэй болж ирж байгаа. Худалдааны нөхцөлүүд маш ийм өөр нөхцөл байдалтай болж ирж байгаа энэ үед бид яаран шийдвэр гаргаж болохгүй гэдгийг л хэлээд байгаа юм.

Түүнээс биш бид зах зээлээ тэлээд явахыг бодолгүй л яах вэ. Гол нь энэ чинь нөхцөл байдал чинь өөрчлөгдөөд байна. Бүх зүйл тодорхойгүй болчихлоо, судалгаанууд чинь хангалтгүй байна гэдгийг л дахин, дахин хэлээд байгаа юм. Тэгэхээр энэ харин ийм чухал шийдвэрийг бид маш олон хүний ирцтэй, Байнгын хорооны дарга өөрөө удирдаад ер нь их тийм арай өөр түвшинд шийдвэр гаргах хэрэгтэй байгаад байна. Энийг чинь ийм хөнгөн хуумгай аргаар шийдвэр гаргаад байж болдог зүйл биш. Түрүүний хэлдгээр бид иргэддээ ч гэсэндээ ААН-үүддээ маш сайн мэдээлэл өгөх ёстой.

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

П.Сайнзориг: Баярлалаа. Би яах вэ зүгээр энэ агуулгын хувьд нэг дотоодын зах зээлийг тэлэх, бид хэд гадаад зах зээл рүү гарах энэ агуулга талаасаа ерөнхийдөө эрэлхийлэх ёстой, явах ёстой гэдэг дээр зарчмын хувьд байгаа. Тэгэхдээ яах вэ зүгээр өнөөдрийн энэ хэлэлцүүлэг явж байгаа хандлагаа бид хэд хаана хаанаа өөрчилье л гэдэг би уриалгыг 1 дүгээрт хэлмээр байгаа юм. Уг асуудлын сайн, муу талыг дэнслээд ийм давуу тал байна, ийм болгоомжлол байгаа. Бид болгоомжлолыг ингэж гэтэлж гарах гэж байгаа гэдэг зүйлээ түвшин түвшинд нь

танилцуулж сурмаар байна. Түүнээс биш одоо л дэлгэрэнгүй ярьж гэдэг зүйлээр биш. Ерөнхийдөө бид хэд нэлээн дэлгэрэнгүй ярьсан хойноо орж ирдэг болмоор байна. Олон нийтдээ, бизнес эрхлэгчдэдээ ойлгуулдаг болчихсон хойноо орж ирмээр байна. Тэгэхээр энэ хандлагыг нэг анхаарч авч үзмээр байна.

2 дугаарт эдийн засаг, төсвийн орлого тийм таатай биш байна. Ер нь хувийн хэвшлийг дэмжих бизнесийн зээлийн олдоц муу байна, зээлийн хүү өндөр байна, ажиллах хүчний хомсдолд орчхоод байна. Дэд бүтцийн хүртээмж ийм муу байгаа. Энэ дээр зүгээр манай хувийн ААН байгууллагуудын бэлтгэл гэдэг юм уу, цаашдаа өсөж томрох тэр бололцоо нь хэр байх юм доо. Энэ дээр төр засаг анхаарна биз. Түрүүн олон хүмүүсийн ярианд гарлаа. Биднээс гэдгийг зөвхөн хувийн хэвшил гэж хэлээд байна биднээс хамаарна гээд. Биднээс гэдгийг 2 ангилж авч үзэх ёстой. 1 дүгээрт хувийн хэвшилд бэлэн байхаас гадна төр өөрөө бэлэн үү, төр энэ хувийн хэвшлийнхээ өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх тэр суурь дэд бүтцийн асуудал болон бизнесийн эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгч чадаж байна уу гэдэг дээрээ нэг маш хурдтай маневртай шийдвэрүүд гаргамаар байна.

Тэгээд яг энэ Евразийн хэлэлцээртэй зэрэгцээд уг нь бизнесийг дэмжих, тэр хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих ч байдаг юм уу ийм хууль, эрх зүйн орчнуудаа цуг оруулж ирээд явбал бид нарт жоохон итгэл үнэмшил төрөх гээд байна. Тэр хуулиуд нь хэзээ орж ирэх, хэзээ үнэхээр Монголын зах зээл дээр хөрөнгө оруулахад боломж гарах гээд байна гэдэг сэдлийг мэдрээд байгаа мөртөө тэр хөрөнгө оруулж ирэх эрх зүйн орчин бүрдэхгүй юм байгаад байна гэдэг харамсалтай. Тэгээд энэ аливаа зүйл дээр энэ бизнесийн төлөөллийг хэлж байгаа танхим байдаг юм уу, мэргэжлийн холбоод яг ойлголтоо нэгтгэмээр байна. Тэгээд бизнесийн юу нь хамтын удирдлагын байгууллага. Ерөнхийлөгч нь дэмжиж байгаа гээд байгаа боловч энэ ААН байгууллагуудын реакцийг харахаар чинь их сонин үзэгдлүүд байгаа байхгүй юу. Энэ дээрээ танхим өөрөө ажилламаар байна. Энэ бизнесүүдтэйгээ ажиллаад ийм байгаа ингэнэ гээд.

Түүнээс биш бүх хэрүүлийг ингээд төрийн институт дээр авчирч ийм зүйл рүү оруулж ирээд байгааг цаашдаа манай танхим анхаараач. Ер шаардлагатай бол хууль, эрх зүйн орчноо ч бүрдүүлээд энэ зүйлүүдээсээ улс төрөөс хараат бус байдал руугаа орох энэ чиг хандлага руугаа ормоор байна. Ийм зүйлүүд хийгдэхгүй бид хэд их л ерөнхий юм яриад л, бие биеэ жоохон нэг чимхэж аваад ийм зүйлүүд байна. Тэгээд асуудлуудыг хэдүүлээ яг бодитой харъя. Гантөмөр сайдыг гэлтгүй ер нь ЗГ өмнөх тэр ЕРА буюу Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрүүдээ нэг дүгнэж үзье, мэдээллээ өгье. Юун дээрээ алдсан юм. Цаашдаа Эдийн засгийн хөгжлийн яамны яг энэ чиглэлийн асуудлыг авч явах хүмүүсээ тогтвортой ажиллуул. Энэ чиглэлийнхээ боловсон хүчнийг сайн бэлд. Ой санамжаа ерөөсөө алдаж болохгүй. Өмнөх зүйлүүд дээр чинь хэн ч хариулж чаддаггүй шүү. Өмнөх зүйлүүдийг байгуулж байсан процессоо хэн ч мэддэггүй. Тэнд юу явж байсныг хэн ч хариулж чаддаггүй. Тэгэхээр манай энэ төрийн ой санамж энэ хэсэг дээрээ ингээд алдагддаг учраас бид хэд дандаа алдаа гардаг.

Тэгээд Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээр энэ хүн хүчээ нэммээр байна. Тэнд чинь энэ олон зүйлүүдийн мэдээлэл авч, энэ бизнесийг гадаад зах зээл дээр яаж гаргах вэ, яаж хамгаалалттай гаргах вэ гэдэг зүйлүүд чинь яригдана. Тэгээд бид хэд энэ дотоодын нэг хэдэн хүндээ найдаад институт нь бэхэждэггүй, нэг газар байгаад байдаг газар нь байнга

өөрчлөгдөж байдаг, ой санамжаа мэддэггүй ийм зүйлүүд байгаа учраас энэ дээрээ хаана хаанаа л.../минут дуусав/

Л.Соронзонболд: Лодойсамбуу гишүүний микрофоныг нээе.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа. Энэ хэлэлцээр явж байгаа юм гэдгийг анх Их Хурлын чуулган дээр хэлж байсан хүний хувьд дээр нь энэ АН-аас сонгогдсон гишүүний хувьд тодорхой нэг зүйлийг залруулж сануулахгүй бол нэг буруу ойлголт яваад байна. Энэ АН Засагт ороод, АН-ын дарга Тэргүүн Шадар сайд болоод, Эдийн засгийн хөгжлийн сайд болоод энэ хэлэлцээрийг хийгээд эхэлчихсэн юм шиг, дотоодын үйлдвэрлэлийнхээ эсрэг хараад зогсчихсон юм шиг ийм ойлголт яваад байгаа. Энэ хэлэлцээ яг одоогийн хэлэлцэж байгаа хэлэлцээ 2022 оноос хойш үргэлжилж байгаа. Тэр чуулганы хуралдаан дээр намайг анх сануулж байхад манайх өөрсдөө дотооддоо хийж чаддаг бүтээгдэхүүн, нэр төрлийн бүтээгдэхүүнүүд бүгдээрээ гаалийн тарифыг нь тэг болгочихсон байсан, тэг болгочихсон.

Үүний дараа Их Хурлын гишүүд, бизнесийн байгууллагууд, үйлдвэрлэгчид саналаа хэлээд Эдийн засгийн хөгжлийн яам саналыг нь сонсоод, 23 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнүүд дээр бид гаалийн тарифыг тэглэж болохгүй юм байна гэдэг саналаа хойд хөрштэй 4 удаагийн хэлэлцээр хийсэн. Ингээд 8-ыг нь хүлээж авах боломжгүй юм байна гээд буцаасан. Одоо үлдсэн дээр нь 40 хүртэлх хувийн гаалийн тариф тогтоосон. Өөрөөр хэлбэл манайх сүү, өндөг, ус, ундаа, архи, пиво өөрсдөө хийж чаддаг бүтээгдэхүүнүүдээ хамгаалж авч үлдэж чадсан шүү. Хүний өөрийнхгүй хэлмээр байна. Энэ загнаад байгаа гишүүд. Яг энэ хэлэлцээр өнөөдрийг хүртэл анх тэр чуулган дээр сануулснаас хойш 4 сар өнгөрч байна. Ямар бүтээлч санал гаргасан юм бэ, ямар хэлэлцээ хийсэн юм бэ? Хэвлэлд гарч ирээд л нэг нэгнийгээ зандраад байдаг, чагнаад байдаг, загнаад байдаг. Энийг бол хэн ч чадна шүү дээ бид. Номхон тэмээ ноолоход амар гэж. Энэ ноолоод байгаа хүн нь нэг их тийм улс төрийн оноо хайгаад л хүмүүстэй нэг их зодолдоод байдаггүй учраас өнөөдрийг хүртэл энэ галтай бүх сэдвийг өөр дээрээ аваад л явж байна. Би Ардчилсан нам энэ хүний нэртэй хамт явж байгаа учраас тайлбар хэлэх нь зүйтэй гэж бодож хэлж байгаа.

Энэ өөрсдөө очоод энэ хэлэлцээрийг хийе гээд гуйгаад явсан хэлэлцээр юм байна лээ. Энийг нь сайнаар хэлэлцье гэж харилцан бие биеийнхээ эрх ашгийг хангая гэж ярилцах нь энэ ЗГ-ын үүрэг болохоос биш тас хийтэл гэдрэгээ харж зогсоод тэр нь АН байгаад энэ хэнд яршигтай юм бэ? Анх тэр тэг хувийн гаалийн тариф тавьсан байсан хүмүүстэй яривал харин жинхэнэ бодитой л алхам болно. Анх яагаад тэглэсэн юм бэ, өөрсдөө хийж чаддаг байсан юмыг. Тэр хүмүүстэй асуудал ярихгүй, тэр тэглэчихсэн байсныг нь харин гаалийн татвартай болгоод, дотоодын үйлдвэрлэлүүдээ хамгаалчихсан сайд руугаа бөөн бөөндөө дайраад байгаа юм. Өөрөө юм хэлэхгүй юм. Өчнөөн хоног сонсоод, өнөөдөр тайлбар хэлж байгаа юм. Өөрөө энэ чуулганы үед сануулж байсан хүний хувьд хэлэхэд. Тэгэхээр цааш цаашдаа бид ингээд нэг ийм олон нийт ингэж бодож байгаа юм чинь гэдэг байдлаар асуудалд ер нь хандмааргүй юм байна лээ. Төрийн ажил байх энэ бас. Энийгээ ер нь хүний өөрийнхгүй анхааръя гэж хэлье.

Д.Соронзонболд: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Энэ түр гэрээг ЗГ-ын төлөөлөл Тэргүүн шадар сайд танилцуулж байгаа юм байна. Мөн Эдийн засгийн хөгжлийн яам, тэгээд Худалдаа, аж үйлдвэрийн танхим үндсэндээ бүх талаас нь дэмжиж оруулж ирж байна гэж ойлгож байгаа. Ялангуяа ХАҮТ-ын байр суурь бол хамгийн чухал. Энэ гишүүнчлэлтэй эвлэлдэн нэгдсэн ийм байгууллагууд. Тэгээд зарим гишүүд хэлж байна. Ингээд төр оролцоно гэхээс илүүтэй энэ бизнес эрхлэгчдийг төлөөлж байгаа энэ байгууллага үнэхээр болно гээд оруулж ирж байгаа юм байна л гэж ойлголоо. Энэ асуулт, хариултын явцад. Тэгэхээр 1 дүгээрт ЗГ-аас оруулж ирж байгаа энэ саналыг Улсын Их Хурал дэмжихгүй бол яах вэ. Тэгвэл та бүхэн цаашид ер нь ямар алхам хийх вэ? Энэ дээр энэ дэмжихгүй байгаа зүйл дээр ямар дүгнэлт хийх вэ гэдэг энэ бол их чухал асуудал. Хэрвээ Улсын Их Хурал дэмжвэл энийг цаашид ер нь хэрхэн дүгнэж явах вэ? Сая ингээд Японтой хэлэлцээр хийсэн үр дүнгийн талаар ингээд зөндөө гишүүд ярьж байна. Ер нь энэ хяналтын механизм мониторингийг тогтмол хийх, хагас жил тутамдаа дүгнээд, тэгээд энийг яг ажил хэрэг болгохын төлөө явахгүй бол ингээд нэг гэрээ хэлэлцээр батлаад, тэгээд мартчих юм бол ширээний нүдэнд хийгээд орхичхоод бид өөрсдөө энэний араас Монголчууд анхаарч, холбогдох байгууллагууд энэ дээр явахгүй бол энэ тэгээд л нэг цаас болоод л үлдэнэ.

Тэгэхээр энэ дээр Монголын тал энэ дээрээ нэлээн идэвх санаачилгатай, ялангуяа ХАҮТ өнөөдөр энд яг болно, дэмжиж байна гэж байгаа энэ байр сууриа хэрвээ дэмжигдсэн тохиолдолд энэний араас явах хамгийн том хувийн хэвшлийн энэ бизнес эрхлэгчдийн өмнөөс явах байгууллага гэж ойлгож байгаа. Энийг би Эдийн засгийн байнгын хорооны гишүүний хувьд хэрвээ энэ Их Хурал дэмжвэл энэний араас байнгын нэхэх болно. Хэрвээ дэмжихгүй бол Улсын Их Хурлын энэ бол шийдвэрийн асуудал. Тэгэхээр олон гишүүд яриад байна. Энэ үндэсний ААН баялаг бүтээж, бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадвар яах вэ гэдэг асуудал байгаа. Тэгээд хамгийн том тулгамдаад байгаа асуудал чинь энэ өндөр хүүтэй зээл аваад байхаар үндсэндээ хөрөнгө оруулалт татаж, энэ зардлаа дарж, илүү ашигтай байх энэ байдал чинь их хүнд байгаад байгаа шүү дээ. Гадаадад өндөр хөгжилтэй, хөрөнгө мөнгө сайтай орнууд энэ зээлийн бодлогоо зөв хэрэгжүүлээд, тэгээд ААН-үүд нь бага хүүтэй 1, 3 хувийн хүүтэй зээл авч байгаа ААН-тэй Монголд 18, 20 хувийн хүүтэй зээл авч байгаа ААН-үүд өрсөлдөхөд аймаар хүнд байхгүй юу.

Тэгэхээр энэ асуудал дээр яаж энэ, Сайнзориг гишүүний хэлж байгаатай адилхан энэ давхар энэ бизнесийн орчныг сайжруулах, эрх зүйн орчныг сайжруулах асуудлыг давхар оруулах юм бэ. Энэ чинь цогцоороо явж байж үр дүнд хүрнэ шүү дээ. Зөвхөн хэлэлцээр байгуулснаараа шууд үр дүнд хүрэхгүй. Ерөөсөө бид ингэж боддог зүйлийг л арилгах ёстой. Энийг цогцоор нь, томоор нь харах ёстой. Энэ механизмыг зөв бүрдүүлж, зөв угсарч, зөв дэмжлэгийн орчныг бүрдүүлж чадвал энэ бизнес чинь өөрөө явна. Чадахгүй бол ингээд төрөөс хамааралтай, шийдвэрээс хамааралтай байгаад л байна. Тийм учраас энэ зүйл.

Хамгийн гол асуудал нь мах болон малын гаралтай түүхий эдийг борлуулах боломж нээгдэнэ л гэдгийг танилцуулаад байгаа шүү дээ. ЗГ-аас оруулж ирж байгаа энэ санал дээр. Тэгээд энэ л жоохон иргэдэд ялангуяа хөдөөгийн малчдад гэрэл гэгээ болж харагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл бид ингээд бэлчээрийн талхлахаас сэргийлэх, малын махны үнэ цэнийг нь нэмэгдүүлэх, ер нь амьсгаанаас нь бусдыг эргэлтэд оруулдаг байсан энэ зүйлийг хүсэж хүлээгээд байгаа шүү дээ. Тэгээд энэ яах вэ дотооддоо малыг эрүүл болгох, бусад зохион байгуулалтын асуудлаас гадна

энийг гадагш нь тэр стандарт шаардлага хангуулахад нь, бусад оронтой тогтмол энэ дээр лабораторийн хувьд дотооддоо.../минут дуусав/

Л.Соронзонболд: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 58,8 хувиар санал хураалт дэмжигдлээ. Батболд гишүүн, Сайнзориг гишүүдийг дэмжсэнээр бүртгэе. Санал хураалт. Байж байгаарай, санал хураалт явуулж дууслаа. Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний түүний гишүүн орнууд хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл танилцуулна. Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

12.50 цаг

Гурав.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

3 дахь хэлэлцэх асуудалд оръё. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Ажлын хэсгийг танилцуулъя. Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Итгэлсүрэн, Монголбанкны Банкны санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Мөнх-Ундрага, Монголбанкны Зээлийн мэдээллийн албаны ахлах хянан шалгагч Дөлгөөн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье. Мөн зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналын томъёоллуудыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20 дахь хэсгийг баримтлан гишүүдээс бичгээр урьдчилан ирүүлсэн бүх саналуудыг танилцуулсны дараа ирүүлсэн дарааллаар нь санал хураалт явуулна. Хамгийн эхэлж дэмжигдсэн саналыг Байнгын хороо дэмжсэнд тооцож бусад саналаар санал хураалт явуулахгүй.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 5 саналын томъёолол ирүүлсэн байна. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.3.Олон улсын жишиг зарчмыг баримтлан Монголбанкнаас тогтоосон нөхцөл шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн үйлчилгээний хөлсийг тогтооно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар, танилцуулсны дараагаар, нэг зүйл дээр 5 санал ирчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр эхлээд уншиж танилцуулах ёстой юм байна. Дахиад уншъя. 2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.3.Энэ хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг тогтоохдоо энэ хуулийн 5.1-д заасан зарчмыг баримталж, тухайн зээлийн мэдээлэлд боловсруулалт хийсэн аргачлалыг ил тод байлгана. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.3.Зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас заасан зарчмыг баримтлан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд тогтооно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ундраа.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14.3.Энэ хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг энэ хуулийн 10.2-т нийцүүлэн үндэслэлтэй тогтооно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг бүхэлд нь хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Болормаа. Санал гаргасан гишүүд саналаа тайлбарлах боломжтой. Миний хувьд гаргасан саналаа татаж байгаа болно. Батнайрамдал гишүүн. Саналаа яах юм бэ, тайлбарлах уу? Батнайрамдал гишүүнд микрофон өгье.

О.Батнайрамдал: Миний санал Сэддорж гишүүний саналтай ер нь зарчмын хувьд, агуулгын хувьд яг ижилхэн байгаа юм. Тийм учраас би саналаа татаад, Сэддорж гишүүний саналыг дэмжээд явчихъя. Баярлалаа.

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүн саналаа татсан тул Сэддорж гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 17 гишүүний 11 нь дэмжиж Сэддорж гишүүний санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж нэг санал ирсэн байгаа. Уншиж танилцуулъя. Төслийн, 6.Төслийн 2 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

10.2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг Монголбанк батална. Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооход ашиглана. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал. Батнайрамдал

гишүүн саналаа тайлбарлах уу? 2 дахь санал, 10.2. Тайлбарласны дараагаар асуулт асууна. Батнайрамдал гишүүн тайлбарлах уу? Батнайрамдал гишүүний гаргасан саналтай холбоотойгоор асуух асуулт асуух гишүүн байна уу? Ганбаатар гишүүн, гишүүний микрофоныг нээе.

Ж.Ганбаатар: 1 асуулт байна. Тэгээд энэ чинь нөгөө энэ би тэгэхдээ энэ эхний хэлэлцүүлэг дээр байгаагүй л дээ. Хэлэлцэх эсэх дээр нь. Тэгэхлээр Батшугар гишүүнээс асууя. Энэ тэгээд энэ хар яг энэ Хар жагсаалт гэдэг зүйл чинь байхгүй болчхож байна уу, байна уу, зарим зүйл дээр нь үлдэж байна уу, зарим зүйл дээр нээлттэй болчхож байна уу гэдгийг нь дахиж нэг тайлбарлаж өгөөч?

Энэ ташрамд 2 зүйл хэлье. Энэ Монголбанк, Сангийн сайд 5 тэрбум долларын нөөцтэй боллоо гээд зарласан. Тэгээд долларын ханш өсөөд байх юм. Өмнөх ЗГ-ын үед намайг Засагт ажиллаж байхад 5 тэрбум долларын нөөцтэй боллоо гэж зарлаад 3550 байсан доллар 3350 болж буусан байхгүй юу. Энэ чинь яагаад эсрэгээрээ юм болоод байна. Энэ чинь худлаа мэдээллээр хүмүүсийг хангаад байгаа юм биш биз дээ Энхтайван даргаа, ерөнхийлөгчөө? Дарга гээд хэлчихлээ уучлаарай, Ерөнхийлөгчөө та энэ буруу мэдээллээр хангаад байгаа юм уу? Яагаад энэ бодит байдал дээр энэ чинь долларын нөөц 5 тэрбум байхад ханш чинь ингээд бүр 600 руу очоод байгаа юм бэ, 3600 руу? Энэ ингээд юуны банкны энэ юу нөөцийн хүү энэ их өндөр байх нь ядуурал их бий болгодог, их олон жил өндөр бодлогын хүүтэй явах бол шууд бизнесийг хаадаг, хүмүүсийн ажил хийх нөхцөл бололцоог хаадаг, хүсэл зорилгыг нь хаадаг. Маш өндөр хүүтэй зээл авах нөхцөл рүү түлхдэг. Банкнууд Монголбанканд мөнгөө хадгалуулаад ажил, зээл өгөх сонирхол нь буудаг. Гаднаас маш бага хүүтэй мөнгө оруулж ирчхээд тэрнийхээ алдагдлыг Монголбанкаар үүрүүлдэг, яривал маш олон юм байгаа шүү. Энэ их тийм ойлгомжгүй зүйл байгаа. Ер нь ойрд Монголбанкныхан ирсэнгүй л дээ. Тэгээд 5 тэрбум долларын нөөцтэй, тэгсэн мөртөө долларын ханш өсөөд байдаг энд юу болоод байгаа юм бэ? Эсхүл Засаг юм уу, эсхүл Монголбанк юу ерөөсөө юу гэж уншигдаж байна гэхлээр долларын ханшийг өсгөх сонирхолтой байгаа юм уу? Юуны алдагдал хаах гээд байгаа юм бэ, яах гээд байгаа юм бэ? Ард иргэдийнхээ, бизнес эрхлэгчдийнхээ хармааг ухна гэж байгаа юм уу нийлж байгаад. Тийм их нөөцтэй юм бол наадхаа буулга л даа. Том асуудал шүү.

Л.Соронзонболд: Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ганбаатар гишүүний асуултад хариулах юм уу, хууль санаачлагч хариулах юм уу? Батшугар гишүүний микрофоныг нээе.

Э.Батшугар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Одоо байгаа тэр ангиллын систем байгаа. Энэ нь хэвийн, анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй, муу гэсэн 5 ангилал байдаг. Албан бусаар хар лист, хар жагсаалт гэж юм яваад байдаг. Энэ нь эхний 2 ангиллаас гараад, сүүлийн 3 ангилал руу орчихоор автоматаар хар жагсаалт бид нарын хэлснээр орчихдог. Үүний үр дагаварт нь 6 жилээр банк санхүүгийн байгууллагууд хаалгаа татчихдаг. Нөгөө иргэн нь зээлээ эргээд төлчихсөн ч гэсэн 6 жилээр байгаад байдаг. Тэгэхээр энэ харгис тогтолцоо бүрэн алга болж байгааг та ойлгож болно. Харин динамик бодит горимоор яриад байгаа онооны систем рүү орж байгаа. Ингэснээр санхүүгийн сахилга баттай иргэдийн оноо нь нэмэгдээд өсөөд явчихна. Хэрвээ тодорхой хэмжээний доголдолт үүсвэл оноо нь буурна, эргээд төлөхөөр эргээд буцаад өсөөд ийм динамик систем рүү орно. Ингэснээр зээлийн хүү буурах нөхцөл үүснэ, барьцаа хөрөнгийн шаардлага буурна. Яагаад гэвэл тухайн оноо нь өөрөө санхүүгийн биет бус хөрөнгө

гээд явчих юм. Тэртээ тэргүй тухайн иргэн өөрийнхөө илэрхийлж байгаа оноогоороо би санхүүгийн сахилга баттай иргэн, зээлийн эргэн төлөх чадвартай гэдгээ илэрхийлээд үзүүлчихнэ. Мөн үүнтэй холбоотойгоор бас эрсдэлийн нийт системийн үнэлгээ ч буурна гэж ойлгож болох юм гэж хэлмээр байна. Баярлалаа.

Л.Соронзонболд: Батнайрамдал гишүүний гаргасан энэ санал дээр нэг анхаарах асуудал байгаа юм байна. Өөрөөр хэлбэл энэ 10.2 дахь, 2 зохицуулалттай өөр утгатай зохицуулалтыг нэг зүйл, заалтад оруулснаараа яг хуулийн техникийн хувьд анхаарах асуудалтай юм байна шүү. Тийм учраас гишүүд үүн дээр анхаарч саналаа өгөөрэй гэж хэлмээр байна. Санал хураалт. Батнайрамдал гишүүнийг дэмжсэнээр тэмдэглэе. Байгаа, арай дуусаагүй, дуусаагүй байна. 17 гишүүн оролцсоноос 1 гишүүн дэмжиж, 5,9 хувиар санал дэмжигдлээ. Санал гаргагчид буцаагдлаа. 1 хүн дэмжсэн.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбоотойгоор 3 санал ирсэн байгаа. 7.Төслийн 3 дугаар зүйл. Зургаа хүртэлх гэснийг гурван гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж.

8.Төслийн 3 дугаар зүйл. Зургаа хүртэлх гэснийг таван гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

9.Төслийн 3 дугаар зүйл. Зургаа хүртэлх гэснийг гурван хүртэлх гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан. Мөнхбаясгалан гишүүн тайлбарлая.

Л.Мөнхбаясгалан: Энэ муу зээлийн жагсаалт руу орохоор 6 жилээр тэр хүн муу зээлийн жагсаалтад хадгалагддаг тийм ээ. Тэгэхээр энэ нь дахиад зээл авахад 6 жилээр тэр хүнийг тарчлааж байгаа байхгүй юу. Одоо яг иргэд, ААН-үүд зээлээс зээлийн хооронд, татвараас татварын хооронд амьдарч байгаа нь үнэн. Тэгэхээр би энд нэмэлт, өөрчлөлт дээр онооны систем рүү шилжингүүт муу зээлийн жагсаалт гэж байхгүй болно гэж сая Батшугар гишүүн хэллээ шүү дээ. Тэгсэн хэр нь яагаад зургаа хүртэлх гэдэг чинь хэвээрээ байгаад байгаа юм бэ? Энийг та нэг сайхан тайлбарлаад өгөөч.

Л.Соронзонболд: Батшугар гишүүний микрофоныг нээе.

Э.Батшугар: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Энэ зургаа гэдэг нь муу, сайн гэж зүйл биш, мэдээлэл нь хадгалагдана гэж байгаа юм. Тэгэхээр хэрвээ таны хэлж байгаа 3 руу орчихоор сайн зээлдэгчийн ч мэдээлэл давхар устаад явчих юм. Нэг ёсны онооны систем рүү орсноор хар жагсаалт гэсэн зүйл огт байхгүй болно. 6 жилээр нөгөө нэг банкнууд болон санхүүгийн байгууллагууд хаалгаа барьдаг ч тэр зүйл байхгүй болно. Цэвэр бодит горимоор явдаг динамик онооны систем рүү ороод, үүгээрээ дамжуулаад бусад банк санхүүгийн байгууллагатай ч гэсэн шууд үйлчилгээ авах нь нээлттэй болчих юм. Гол нь оноо нь байгаа юм.

Тэгэхээр юутай холбоотой вэ гэхээр сайн зээлдэгч ч байж болно, 6 жил сайн мэдээллээ хадгалж болно. Хэрвээ тодорхой хэмжээний оноо нь буурчхаад тэгээд эргээд зээлээ төлөөд явчихвал нөгөө оноо нь автоматаар өсөөд л явчихна. Ахиж 6 жилээр хар жагсаалт зүйл байхгүй. Харин тийм динамик амьд горимын системд орох гэж байгаа юм. Цаашлаад хэлэхэд энэ системд орсноороо илүү санхүүгийн

сахилга баттай иргэдийг дэмжинэ, илүү урамшуулдаг систем рүү орно, барьцаа хөрөнгийн шаардлага нь буурна. Яагаад гэвэл тухайн хүний оноо нь өөрөө санхүүгийн биет бус хөрөнгө болчихно, тухайн хүний баталгаа болчихно. Одоо байгаа систем нь төлөхгүй байхаар автоматаар хар жагсаалт руу ороод, тэр 6 жилээр хаалгаа барьчихдаг. Энэ зүйл би ахиад хэлье байхгүй болно гэж хэлмээр байна Мөнхбаясгалан гишүүнээ. Харин эсрэгээрээ илүү урамшуулдаг систем рүү орно. Тэгээд нийгмийн үр дүн нь ингэснээр зээлийн хүү тодорхой хэмжээгээр буурах суурь нөхцөл үүссэн. Жишээлбэл танд хэлэхэд Латин Америкт энэ онооны систем рүү орсноор зээлийн хүү 3,4-өөс 3,6 нэгж хувиар буурсан. Энийг Монгол руу хөрвүүлбэл яг л 2-оос 4 хувиар буурах бололцоо байгаа юм байна лээ.

Л.Соронзонболд: Би өөрийнхөө саналыг нэг тайлбарлачихъя гэж бодож байна. Энэ зургаа хүртэлх гэхээр тухайн зээлдэгчийн хувьд зарим зээлдэгчид 1 жилээр, заримд нь 3 жилээр, заримд нь 6 жилээр гээд ийм тэгш бус хандах нөхцөл үүсэх юм биш үү? Тийм учраас их тодорхой байх нь зүйтэй гэж үзсэн 1 дүгээрт. 2 дугаарт болохоор ер нь олон улсын туршлагыг харахад ихэнх улсууд орнууд ер нь дунджаар 5 жил байдаг юм байна лээ. Тийм учраас би 5 жил гэж ийм санал гаргасан юм. Мөнхбаясгалан гишүүн тайлбарлах, дахиад тайлбарлах уу өөрийнхөө саналыг?

Л.Мөнхбаясгалан: Би өөрийнхөө саналыг татлаа.

Л.Соронзонболд: Мөнхбаясгалан гишүүн саналаа татлаа. Санал хураалт явуулъя. Эхний санал 7.Төслийн 3 дугаар зүйл. Зургаа хүртэл гэснийг гурван гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж. Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй.

Санал хураалт. 8.Төслийн 3 дугаар зүйл зургаа хүртэлх гэснийг таван гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 76,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Энэ чинь, энэ хамаагүй биз дээ? Одоо энэ байхгүй болчихсон шүү дээ, хураах юм уу? Энэ санал гаргасан учраас заавал хураах ёстой юм байна. Саналын томьёолол. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн зургаа хүртэлх гэснийг гурван гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж. Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа дээр нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хороо Жамбаажамцад тус тус даалгасугай. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 10 гишүүн дэмжиж, 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Батсүмбэрэл гишүүнийг дэмжсэнээр тэмдэглэе. Өнөөдрийн хурал дууссан уу? Хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жаргалан уншиж танилцуулна.

13.10 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, Ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

